


ШИНЭ НОМЫН МЭДЭЭ

2020 №03



Эмхтгэсэн: Ном зүйч С.Найгалмаа
Н.Энхтуяа

Улаанбаатар хот
2020 он

ГАРЧИГ

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН. ЭКОЛОГИ.....	1
ФИЗИК-МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1-2
ГЕОЛОГИ, ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН.....	2-3
БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	3
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААН.....	4
НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	4
ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	4-12
ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	13-15
УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	15-18
ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН.....	18-21
ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	21-22
СОЁЛ СУДЛАЛ.....	22-23
ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ.	23-25
БОЛОВСРОЛ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН.....	25
СЭТГҮҮЛ ЗҮЙ.....	25-27
ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	28-32
АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ.....	33
УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ.....	33-34
УРАН ЗОХИОЛ.....	34-35
УРЛАГ. УРЛАГ СУДЛАЛ.....	35-37
ШАШИН СУДЛАЛ.....	37-41
ГҮН УХААН.....	41-45
СЭТГЭЛ СУДЛАЛ.....	45-47
НОМ ЗҮЙН ЛАВЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА.....	48
ГАДААД ХЭЛ ДЭЭРХ НОМ, ЗОХИОЛ.....	49-52

Товчилсон үгийн тайлбар:

БУУТ- Байгалийн ухааны уншлагын танхим /306 тоот/

НХУУТ- Нийгэм, хүмүүнлэгийн ухааны уншлагын танхим- I,II /211, 108 тоот/

ГНОФ- Гэрээр ном олгох фонд-I,II,III /110,201,401 тоот/

ГФ- Гадаад номын фонд /411 тоот/

ЛавФ- Лавлагааны фонд /409 тоот/

ЭШФ- Эрдэм шинжилгээний фонд /411 тоот/

БС- Бизнесийн сургуулийн номын сан /Хич-V 505 тоот/

ХЗС- Хууль зүйн сургуулийн номын сан /Хич-III 205 тоот/

ОУХНУС- Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын

сургуулийн номын сан /Хич-V 304 тоот/

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН. ЭКОЛОГИ

Алтансүх О. Хүрээлэн буй орчин судлалын нэр томъёоны англи-монгол тайлбар толь, монгол-англи толь бичиг = **English-Mongolian glossary Mongolian-English dictionary of environmental science** / Орч. О.Алтансүх; Техник ред. Т.Номин-Эрдэнэ, М.Энх-Үүр, А.Энхмэнд; Хян. Н.Батсайхан, Е.Батчулуун, М.Одсүрэн; Шүүмж. Д.Даваадорж, Н.Оюунчимэг.- УБ.: МУИС пресс, 2020.- 114х.- ISBN 978-9919-23-689-2.



Тус бүтээлд хүрээлэн буй орчин судлалын шинжлэх ухаанд өргөн хэрэглэгддэг 860 орчим нэр томъёог англи-монгол, монгол-англи тайлбартайгаар эмхэтгэжээ. Үүнд биологи, экологи, хими, физик, газар зүй, дэлхий судлал, нийгэм, эдийн засаг, улс төр гэх мэт салбар дундын шинжлэх ухааны олон нэр томъёог багтаасан байна. Энэхүү толь бичгийг экологи, хүрээлэн буй орчин ба байгаль хамгаалалын чиглэлээр суралцаж буй оюутан, багш, судлаачид болон нийт уншигч, сонирхогчдод зориулжээ.

20.1я2

А 486

/БУУТ-3, ГНОФ-5/

ЭШФ Т-23641-23642

ФИЗИК-МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Ньютон И. Байгалийн философийн математикийн эхлэл: Шинжлэх ухааны сонгодог бүтээл / Орос хэлнээс орч. Д.Төмөрбаатар; Редакцийн зөвлөл Г.Шилагарди, Э.М.Шпилевский, Д.Улам-Оргих.- УБ.: Соёмбо принтинг, 2020

Исаак Ньютоны агуу нээлтүүд нь хүн төрөлхтний сэтгэлгээнд хувьсгалт эргэлт гаргасан төдийгүй XVI-XVII зууны турш механик, физик, астрономийн чиглэлээр гарсан гарамгай ололт бүхнийг нэгэн үзэл санаанд нэгтгэн нэгдмэл тогтолцоог бий болгож, цаашдын чиг хандлагыг тогтоож өгсөн гэж судлаачид үздэг. Тус 3 боть бүтээлд биеийн хөдөлгөөн түүний масс, хүч, инерци, импульс зэрэг физикийн үндсэн ойлголтууд болон дэлхий ертөнцийн таталцлын хуулийн онолын томъёолол, Кеплерийн бүх хуулийн математик гаргалгаа зэрэг түүний алдартай нээлтүүдийн тухай чухал баримтуудыг оруулсан байна. Энэхүү номыг философи, байгалийн шинжлэлийн мэргэжилтэн, судлаач, багш оюутнууд шинжлэх ухааны түүх сонирхогч, өргөн олон уншигчдад зориулжээ.

22г

Н 897

Б.1: Биеийн хөдөлгөөний тухай.- 453х.- ISBN 978-9919-23-058-6.

/БУУТ-5, ГНОФ-5/ ЭШФ Т-23589-23593

Б.2: Биеийн хөдөлгөөний тухай.- 250х.- ISBN 978-9919-23-059-3

/БУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т-23594-23598




Б.3: Ертөнцийн тогтолцооны тухай.- 210х.- ISBN 978-9919-23-060-9.

/БУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т-23599-23603

ГЕОЛОГИ. ГАЗАР ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН

Монгол орны регионал стратиграфи = Regional stratigraphy of Mongolia / Д.Доржнамжаа, Я.Бат-Ирээдүй, Н.Ичинноров ба бус.; Ред. Ё.Ханд, Г.Сэрмаа; Хэвлэлийн эх бэлт. Д.Доржнамжаа, Б.Энхбаатар, Г.Алтаншагай.- УБ.: Адмон принт, 2017.- 267х.- (Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи. Палеонтологи, Геологийн хүрээлэн).- ISBN 978-99973-0-947-1



Монгол орны нутаг дэвсгэрт сүүлийн 70 гаруй жилд нийгэм эдийн засгийн хөгжлийн янз бүрийн үе шатанд явагдсан геологийн эрэл хайгуул, 1:1000 000, 1:200 000 болон 1:50 000-ын масштабын геологийн зураглал, ерөнхий эрэл болон төрөл бүрийн сэдэвчилсэн судалгааны явцад илэрч тогтоогдсон метаморф, вулканоген, тунамал хурдсуудын регионал стратиграфийн нэгдсэн схем, ангилал, харьцуулалтыг нийт нутгийн хэмжээнд нягтлан боловсруулж олон улсын ангилалд дүйцүүлсэн үр дүнг тус эмхэтгэлд багтаасан байна.

26.3(1)

М 692

ЭШФ Т-23784

Доржнамжаа Д. ба бус. **Монгол орны алмаасжилттай астропайп геобүтэц ба Баянхонгорын эртний арлан нумын алт-цул сульфидын хүдэржилтийн зүй тогтол = Mongolian diamond-bearing astropipe geostructure and regularity of formation, development of gold-massive sulphide mineralization of the bayankhongor paleoisland arc /** Д.М. Воинков, Б.Энхбаатар; Ред. Б.Дэлгэрцогт.- УБ.: Blue sky, 2013.- 151х.- (МУ-ын ШУА. Палеонтологийн төв).- ISBN 978-99973-819-0-3.



Уг бүтээлд Монгол орны Улаан булаг, Агьт хангай, Хүрээ мандал, Цэнхэр, Баянхүрээний астропайп геобүтцийн судалгаа, цул сульфидын орд газруудын хүдэржилтийн ерөнхий зүй тогтол, гарал үүсэл, хүдрийн талбайд хийгдсэн геофизикийн судалгааг дэлхийн сайтар судлагдсан цул сульфидын томоохон газруудын бүрэлдэн тогтсон нөхцөл, гарал үүсэл, цаг хугацаа, орон зайн зүй тогтол, тэдгээрийн онцлог байдлын судалгаанд тулгуурлан харьцуулах замаар судлан тайлбарлажээ.

26.34(1-M3)

Д 542

ЭШФ Т-23785

Монгол орны газарзүйн дэвсгэр нэрийн тайлбар толь / Ред. Д.Даш, М.Уртнасан; Эх бэлт. А.Мөнгөнхуяг; Хавтасны диз. Д.Энхбаяр.-УБ.: Ном хур, 2020.- 216х.- (ШУА. Газарзүй-Геоэкологийн хүрээлэн).- ISBN 978-9919-23-002-9.

Тус бүтээлд газарзүйн 500 шахам дэвсгэр нэрийг тусган оруулж, нэр тус бүрийг тайлбарлажээ. Мөн газар зүйн зурагт тэмдэглэсэн нэрүүдээс тодорхой жишээг сонгон оруулахдаа уг зураглалын ажлын үр дүнгээс хэсэгчлэн авсан нийт 447 газрын зурагт байршлыг заан, тухайн байгалийн дүр төрхийг илтгэсэн 195 гэрэл зургийг хавсаргасан байна.

26.8(1)я2

М 692

/БУУТ-2/

ЭШФ Т-23561-23563



Дагвадорж Д. **Уур амьсгалын өөрчлөлтийг тооцсон тэнцвэрт хөгжлийн загвар** / Хян. Д.Доржготов.-УБ., 2020.- 404х.- ISBN 978-9919-23-400-3.

Энэхүү номонд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бүхий л асуудлыг ухаалгаар тооцсон хөгжлийн загваруудын үндэслэл, зарчим, хамрах хүрээ, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга зам, хөшүүргийн талаар авч үзсэн байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг цогцоор нь тооцсон

хөгжлийн загваруудыг боловсруулахдаа судлаач маань өөрийн олон жилийн судалгаа болон олон улсын байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагууд, манай орны эрдэмтэн судлаачдын хийсэн судалгааны хамгийн сүүлийн үеийн мэдээлэл, ололт, дүгнэлт, тайлан эх сурвалжид үндэслэн боловсруулжээ.

26.23

Д 156

/БУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23564-23566



БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Монгол орны бактерийн палеонтологи = Bacterial paleontology of Mongolia / Д.Доржнамжаа, Я.Бат-Ирээдүй, Н.Ичинноров ба бус.; Ерөн. ред. Д.М.Воинков; Хэвлэлийн эх бэлт. Д.Доржнамжаа, Я.Бат-Ирээдүй, Г.Алтаншагай ба бус.- УБ.: Адмон принт, 2018.- 177х.- (Монгол Улсын Шинжлэх Академи. Палеонтологи, геологийн хүрээлэн).- ISBN 978-99978-4-710-2.

Тус бүтээлийг бактерийн палеонтологийн судалгааны үндэслэл, онцлог, арга аргачлал, хөгжил ба танин мэдэхүйн тухай ойлголт, монгол оронд хийгдсэн бактерийн палеонтологийн судалгааны үндсэн үр дүн ба эдиакари-доод кембрийн хил заагийн асуудлын тухай тодорхой мэдээллийг салбарын судлаачид, палеонтологч, геологич мэргэжилтнүүдэд хүргэхийг зорьжээ.

28.1(1)

М 692

ЭШФ Т-23783



АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААН

Сиддарта М. **Хорлолын хаан** = **The emperor of all maladies**: Хорт хавдартай тэмцсэн түүх: Пулицэрийн шагналт бүтээл / Ред. Б.Нэргүй; Орч. Б.Гэрлээ; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Нэпко, 2019.- 450х.- ISBN 978-9919-500-25-2.



Энэхүү номд хүн төрөлхтнийг эртнээс нааш дагасан хорт хавдрын түүхийг өгүүлсний дээр уг өвчнийг задлан шинжилж, гарал үүслийг нь тодруулан, нууцлаг бүхнийг нээн харуулахын сацуу хамгийн гол нь алс ирээдүйд уг өвчнийг хэрхэн эмчилж, яаж үндсээр нь устгаж үгүй хийх талаар тусгажээ. Мөн дээр дурдсан эмчлүүлэгчдийн өгүүлсэн өвчний түүх болон нөхцөл байдлууд бүгд бодит гэдгийг энд хэлэх нь зүйтэй биз ээ.

55.6

С 435

/БУУТ-7/

ЭШФ Б-29784-29786

НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН

Нарантуяа Д. **Монголын нийгэм ба шүтээн**: 1-р дэвтэр: 1921-2005 / Хян. Ж.Лхагвадэмчиг; Хавтасны зур. Д.Нарантуяа, Т.Билгүүдэй.- УБ.: МУИС пресс, 2020.- 220х.- ISBN 978-9919-23-892-6.



Уг бүтээлийг 58 хүний амьдрал, сүсэг бишрэлийн тухай аман түүх, албаны хүмүүстэй хийсэн ярилцлагууд болон холбогдох баримт сэлтэд үндэслэв.

Мөн энэхүү судалгааны ажлыг дараах 3 асуудлын хүрээнд судалсан болно.

1. 1930 аад оны хэлмэгдлийн дараа хүн амын шашин шүтлэг, зан үйл хэрхэн өөрчлөгдсөн бэ?
2. Монголчуудын шашин, сүсэг бишрэлд улс төр, эдийн засаг, нийгэм соёлын өөрчлөлт хэрхэн нөлөөлсөн бэ?
3. Христийн шашинд татагдах гол хүчин зүйлс юу байв?

60.56(1)+86.2

Н 294

/НХУУТ-7/

ЭШФ Б-29799-29801

ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН

Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг / Эрхлэн хэвл. На.Сүхбаатар; Цувралын ред. Б.Түвшинтөгс; Хян. Л.Энхсаруул, Т.Ганцогт, Г.Мандахбаяр; Кирилл бичигт хөрв. Э.Тугмандал, Б.Амгаланбаатар, А.Мөнхбаяр ба бус.; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- (Түүх соёл, хэл бичиг судлалын Тод номын гэрэлт төв: Bibliotheca oiratica)



Энэхүү цуврал бүтээл нь Алшаа вангийн хошуунд хадгалагдаж байсан монгол орчуулгыг МУ-ын Үндэсний номын сангийн сан хөмрөгт буй орчуулгаас нөхвөрлөн 1992 онд хэвлүүлснийг баримтлан кирилл бичгээр хөрвүүлэн буулгаж, орчуулгын алдаа мэдгийг манж, хятад эхтэй тулган залруулж, албан тушаал болон нэр томьёонууд нь хятад хэлээр бичигдсэн байсныг мөн орчуулан хүргэж буйгаараа онцлог бүтээл юм.

63.2(1)

Б 472

Цувр.85: Дэвт. 1-13.- 232х.- ISBN 978-99978-987-3-5.

/НХУУТ-5, ГНОФ-8/ ЭШФ Т-23666-23670

Цувр.86: Дэвт. 14-26.- 240х.- ISBN 978-99978-981-3-5.

/НХУУТ-5, ГНОФ-8/ ЭШФ Т-23671-23675

Цувр.87: Дэвт. 27-38.- 224х.- ISBN 978-99978-987-3-5.

/НХУУТ-5, ГНОФ-8/ ЭШФ Т-23676-23680

Цувр.88: Дэвт. 39-48.- ISBN 978-99978-987-3-5.

/НХУУТ-5, ГНОФ-8/ ЭШФ Т-23681-23685

Дайчин улсын түүхийн товчоон: Тэргүүн боть / Монгол бичгээс хөрв. Г.Сэр-Од; Хян. Ц.Цэрэндорж.- УБ.: Архивын ерөнхий газрын хэвлэх, 2019.- 142х.- ISBN 978-9919-9577-2-8.

Тус эмхэтгэл нь Дай Чин улсын төрөөс зохиолгосон "Бодлогын бичиг" тэргүүтэй албан түүхийн зохиолуудын Монголын түүхтэй холбоотой мэдээнүүд багтсанаараа эрдэм шинжилгээ судалгааны ихээхэн ач холбогдолтой бүтээл болно. Зөвхөн Монголын түүхэнд холбоотой мэдээ төдийгүй, Манжийн гарал үүсэл, мандан гарсан үеийн түүхийн мэдээ, Манж Зүрчидийн угсаатны зүйн холбогдолтой мэдээ баримт, Түвэдийн түүхийн мэдээ баримтууд багтжээ.

63.3

Д 196

ЭШФ Т-23780-23782

Дэлхийн түүхэн товчоон = Timelines of everything: Арслан заанаас дэлхийн дайн хүртэл / Орч. Д.Хүрэлхүү, Т.Ариунсанаа; Ерөн. ред. Д.Хүрэлхүү; Ред. В.Уянга, Б.Гэрлээ, Б.Оюунчимэг.- УБ.: Нэпко, 2019.- 320х.: Зур.- ISBN 978-99195-0-017-7.

Дэлхийн болон хүн төрөлхтний түүхийн гол үйл явдлуудыг тоймлон багтаасан энэхүү зурагт товчоонд эзэнт улсуудын мандал, мөхлөөс эхлээд бидний амьдралыг өөрчилсөн шинэ шинэ нээлт, шинжлэх ухааны ололт амжилт болон урлаг уран сайхны үе үеийн урсгал чиглэлийн төлөөлөл болсон шилдэг бүтээл зэрэг нийгмийн бүхий л салбарын түүхийг багтаажээ. Гоёмсог зураг чимэглэл, сонирхолтой



баримт, нарийн мэдээллүүдийн цогц болсон "Дэлхийн түүхэн товчоон" ном нь дэлхийн түүхийн талаарх хамгийн шинэлэг, хамгийн чухал гарын авлага ажээ.

63.3(0)я2

Д 893

/НХУУТ-9/

ЭШФ Т-23519-23521

Паркэр Филип. **Дэлхийн түүхийг өөрчилсөн тулалдаанууд = Battles that changed history:** Домогт тулалдаануудыг шинжлэн тайлбарлав / Р.Ж.Грант, Хамфриз Эндрю; Орч. Д.Хүрэлхүү; Ред. Б.Гэрлээ.- УБ.: Нэпко, 2019.- 256х.: Зур.- ISBN 9789919500078.



Дэлхийн түүхийг өөрчилсөн тулалдаанууд хэмээх энэ номонд хүн төрөлхтөн үүссэн эрт балар цагаас эхлэн цөмийн дайны эрин үе хүртэл дэлхийн түүхэнд цуутай 90 гаруй дайн тулааны тухай онц сонирхолтой өгүүлжээ. Дайн тулаантай холбоотой газрын зураг, уран зураг, эд өлгийн дурсгал болон түүхэн гэрэл зургаар дамжуулан гол тулалдаануудыг дүрслэн харуулж, дайны тактикийн чухал шийдвэрүүд түүхийн хүрдийг хэрхэн эргүүлэн өөрчилж байсныг уншигч та энэхүү номноос мэдэх буй заа.

63.3(0)

П 182

/НХУУТ-9/

ЭШФ Т-23516-23518

Юань, Мин, Чин улсын хаадын оны тоолол, сар өдрийг тайлж унших гарын авлага / Эрхл. На.Сүхбаатар; Орч. Тайлбар үйлдсэн Л.Энхсаруул, Б.Баяндалай; УБ.: Соёмбо принтинг, 2019.- 184х.- (Түүх соёл, хэл бичиг судлалын Тод номын гэрэл төв).- ISBN 978-99978-71-36-7.



Тус гарын авлагыг Фан Шы Мин, Фан Шао Фэнь нарын эмхэтгэсэн "Хятадын түүхэн он дараалал ба хятад, өрнийн түүхэн он дарааллын хүснэгт 2" дахь Юань улс, Мин улс, Манж Чин улсын он тооллуудыг хятад эх сурвалжаас монгол хэлнээ буулгажээ. Харин Фан Шы Мин, Фан Шао Фэнь нар нь өөрсдийн бүтээлдээ Луо жэнь юугийн "Нийтийн тооллоос нааших илүү сарын шинжилгээ" болон Шэү Жун Сань, Оу Ян И нарын "Хятад, өрнийн 2000 жилийн харьцуулсан хүснэгт", мөн Хуан бо лугийн "Хятад, өрнийн жил сарын бүрэн шинжилгээ" зэрэг түүхийн баримт сурвалжуудыг ашигласан ажээ.

63.3(0)2я7

Ю 121

/НХУУТ-5/

ЭШФ Т 23711-23715

Баттулга Ч. **Монгол орон судлал:** Монгол хэл сурч буй гадаадынхан болон монгол орноо танин мэдэхийг хүссэн хүн бүхэнд зориулав / Хян. Д.Баттогтох; Эх бэлт. Д.Оюун; УБ.: Адмон принт, 2020.- 214х.- ISBN: 978-9919-23-667-0.



Монгол улсын засаг захиргааны нэгж ба нутаг дэвсгэр, хүн ам, монгол орны байгаль цаг агаарын онцлог, байгалийн баялаг гээд ерөнхий мэдээллээс эхлэн монголчуудын эрхэлдэг аж ахуй, оромж сууц, хувцас хунар, хоол хүнс,

тоглоом наадгай гээд эд өлгийн зүйлс, улмаар монголчуудын оюуны өв соёл, үндэсний урлагийн гайхамшиг, монголын түүх, шашин, хэл, соёл, боловсрол, ёс заншил зэрэг өргөн хүрээг хамарсан мэдээллийн чанартай энэхүү лавлах бүтээлийг монголыг сонирхогч гадаадынханд зориулсан байна.

63.3(1)

Б 341

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т-23703-23707

Богд хаан-150: Түүх, соёл, өв: Олон улсын эрдэм шинжилгээний хурлын өгүүллийн эмхэтгэл / Эмхт. О.Батсайхан, У.Загдцэсэм; Диз. Т.Анхбаяр.-УБ.: Бит пресс, 2019.- 463х.- (МУЕТГ. БСШУСЯ. ШУА-ийн ОУХХ).- ISBN 978-9919-22-806-4.



Үндэсний эрх чөлөөний хувьсгалын оюун санааны удирдагч, Монгол Улсын хаан, Наймдугаар Богд Жавзандамба хутагтын мэндэлсний 150 жилийн ойд зориулсан тус хуралд Монгол, ОХУ, БНХАУ, Япон, ХБНГУ, Унгар, Польш зэрэг орноос 33 эрдэмтэн, судлаач оролцож илтгэл хэлэлцүүлсэн. Мөн Монгол Улсын ШУА-ийн салбар хүрээлэнгүүд, их сургуулиуд, Гандантэгчэнлин хийд, Богд хааны ордон музей зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын төлөөлөл оролцож, ХХ зууны эхэн үеийн Монголын түүх, соёл, шашин, урлаг, уран зохиол, Богд хааны амьдрал, улс төр, шашны үйл ажиллагаа, төрийн зүтгэлтнүүд, Богд хаант Монгол Улсын Засгийн газар, түүний үйл ажиллагаа, дотоод, гадаад бодлого зэрэг сэдвийн хүрээнд хийгдсэн хэлэлцүүлгийн тоймыг эмхэтгэжээ.

63.3(1)

Б.525

/НХУУТ-5, ОУХНУС-1/

ЭШФ Т-23546-23549

Дашдаваа Ч. Бүтээлийн чуулган: 5 боть.- 2 дахь хэвл.- УБ.: Бэмби сан, 2019.- (МУ-ын ШУА.Түүхийн хүрээлэн. СУИС. Улаанбаатар-Эрдэм судлал дээд сургууль).

Б.1: Улаан түүх: Коминтерн ба монгол / Ред. Л.Бат-Очир; Техник ред. Ч.Болд; Эх бэлт. Л.Мөнхболд.- 364х.- ISBN 978-9919-22-568-1.



Тус бүтээлд БНМАУ-ын 1920-1930-аад оны үеийн нийгэм улс төрийн нөхцөл байдлыг судлан шинжилсэн байна. 1921 онд хувьсгал ялснаар Монголын улс төр, нийгэм-эдийн засаг, оюун санааны амьдралд ихээхэн өөрчлөлт гарсан. Гэвч Зөвлөлт Оросын Коминтерний шахалтаар Монгол улс Коминтернд элссэн. Энэ цаг үеэс эхлэн Коминтерний зүгээс манайд хэрэгжүүлсэн бодлого, байр суурь, санал зөрөлдөөн, хэлмэгдүүлэлт, төрийн эргэлт, социализм байгуулах оролдлого, шинэ эргэлтийн бодлогын хэрэгжилт, амжилт болон бэрхшээлийн талаар түүхэн баримт, эх сурвалжид тулгуурлан баримт нотолгоотой бичсэн байна.

63.3(1)

Д 393

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т 23574-23576

Б.2: Монгол дахь төрийн эргэлт / Ред. Б.Даш-Ёндон; Техник ред. Ч.Болд; Диз. Ч.Эрдэнэбат.- 2020.- 375х.- ISBN 978-9919-23-690-8; ISBN 978-99929-77-34-5.



Монгол оронд 1928 оны эцэст Коминтерны зүгээс төрийн эргэлт зохион байгуулсан. Монголчуудын хүсэл зоригоос гадуур хийгдсэн энэхүү улс төрийн үйл явц нь Зөвлөлт Орос улс болон Коминтерны зүгээс Монгол орныг өөрийн нөлөөлөлд баттай байлгахад чиглэсэн олон бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилт, тэдний сөрөг байр суурийн талаархи асуудлыг судлан шинжилж, энэхүү нэг сэдэвт бүтээлд тусгасан байна.

63.3(1)

Д 393

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т-23577-23579

Б.3: Коминтерний төлөөлөгчид / Ред. Ц.Энхээ; Техник ред. Ч.Болд; Диз. Ч.Эрдэнэбат.- 584х.- ISBN 978-9919-22-939-9.



Тус ботид Коминтерны үзэл санааг Монголд хэрэгжүүлэх үйл хэргийг Сталины даалгавраар хариуцан гүйцэтгэсэн Коминтерны элч Шалва Элиава, бүрэн эрхт төлөөлөгч Сергей Миронов, Коминтерны хамгийн сүүлийн төлөөлөгч Черномордик нарын үүрэг гүйцэтгэх хугацаандаа хэлсэн үг, яриа, нууц бичиг захидал, илтгэл, тайлан, нот бичиг зэрэг түүхийн баримтууд багтжээ. Коминтерны төлөөлөгч нарын үзэл бодол үйл ажиллагааг шинжлэн дүгнэх нь судлаачдад амаргүй ажил боловч ХХ зууны Монголын түүхийг хойч үедээ үнэнээр нь өгүүлэхийн тулд эдгээр баримтуудыг судлан шинжилж, тэдний байр суурийг тодорхойлохыг зорьжээ.

63.3(1)

Д 393

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т-23580-23582

Б.4:Пэлжидийн Гэндэн: БНМАУ-ын Ерөнхий сайд П.Гэндэнгийн мэндэлсний 125 жилийн ойд зориулав / Техник ред. Ч.Болд; Диз. Ч.Эрдэнэбат.- 356х.- ISBN 978-9919-23-569-7.



Тус ботид БНМАУ-ын Ерөнхий сайд П.Гэндэнгийн улс төрийн үйл ажиллагаа, тэмцэл, Коминтерний талаархи түүний үзэл бодол, байр суурь болон Орост биеэ эмчлүүлэх гэж очоод баривчлагдсан, цаазлагдсан тухай архивын баримт бичиг, судалгаа, сурвалжийн орчуулга, тайлбар оржээ. Мөн Ерөнхий сайд А.Амар, Бага хурлын Д.Догсом, Д.Лосол, маршал Г.Дэмид, Сангийн Яамны сайд С.Довчин нарт холбогдох архивын материалууд багтсан байна. Энэхүү номыг ХХ зууны монголын түүхийг сонирхон судлагч өргөн олон уншигчдад зориулав.

63.3(1)

Д 393

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т-23583-23585

Б.5: Японы олзлогдогсод Монголд / Зөвл. Ока Хироки; Техник ред. Ч.Болд; Диз. Ч.Эрдэнэбат.- 270х.- (Япон сан. Тохоку Их Сургуулийн Зүүн Хойд Ази Судлалын Төв. Монгол Улаанбаатар их сургууль).- ISBN 978-99962-3-177-3.



Монгол дахь японы олзлогдогсдын тухай асуудал бол Монгол, Японы төдийгүй бусад орны судлаачдын анхаарлыг татсаар ирсэн сэдвийн нэг ажээ. Энэхүү судалгааны бүтээлд Дэлхийн 2-р дайны төгсгөл үе ба Японы олзлогдогсод Монголд ирсэн болоод тэдний Монголд амьдрах хугацааны аж амьдрал, хөдөлмөр бүтээл, ял шийтгэл, үйлдсэн гэмт хэрэг, өвчин эмгэг ба нас баралт, амьд үлдэгсдийг эх нутагт нь буцаах үйл ажиллагаа, түүнчлэн монгол япон хүмүүсийн харилцаа болон манайд байгаа япончуудын булшны асуудал тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаар түүхийн баримт, судалгаа шинжилгээний өгүүлэл, материалууд орсон байна.

63.3(1)

Д 393

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т-23586-23588

Жамсран Л. Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт: Түүхч Л.Жамсрангийн мэндэлсний 90 насны ойд / Эх бэлт. Б.Бауыржан, М.Лхамжав.- 2 дахь хэвл.- УБ.: Мон-Лойс, 2019.- 380х.- (ШУА. Түүхийн хүрээлэнгийн Олон улс судлалын төв).- ISBN 978-9919-22-276-5.



Тус нэгэн сэдэвт бүтээлд ХХ зууны Монголын төрийн тусгаар тогтнолын түүхийг он цагаар нь гурав хуваан авч үзжээ. 1900-1919 он: Цагаагчин гахай жилийн хувьсгал ба тусгаар тогтносон Монгол, Хятад хоёр улсын харилцааны эхлэл, Дундад Иргэн Улс ба Хаант Орос улс хоёроос Монголын тусгаар тогтнолыг үл зөвшөөрсөн түүхийн ээдрээтэй цаг үе болон Монголчуудын тэмцэл, 1920-1930 он: Монголд өрнөсөн хувьсгалын ялалт, тусгаар тогтносон Монгол улсын гадаад харилцаа, Хятадын эрх чөлөөний тэмцлийг дэмжсэн гадаад бодлого, 1931-1949 он: Японы түрэмгийллийн үе, Их гүрнүүд БНМАУ тусгаар тогтнолын талаар тохиролцоонд хүрсэн, Дундад иргэн улс БНМАУ-ыг хүлээн зөвшөөрсөн ба Монгол улс БНХАУ-тай харилцах эхлэл тавигдсан цаг үеүүдийн түүхийг хамруулжээ. Энэхүү бүтээл нь монголын төрийн тусгаар тогтнолыг тусгайлан авч үзсэн бөгөөд өдгөө нэн ховордсон түүхэн зохиол ажээ.

63.3(1)

Ж 235

/НХУУТ-5/

ЭШФ Б-29790-29793

Латтимор О. Нүүдэлчид ба хувьсгалчид: Монголд эргэн зочилсон нь: Нэрт монголч эрдэмтэн О.Латтиморын мэндэлсний 120 жилийн ойд зориулав / Орч. Ц.Батбаяр, Э.Пунцаг; Эрхл. Д.Золбоо, Р.Төрдалай, З.Батчимэг; Эх бэлт. Ц.Амартүвшин.- УБ.: Бэмби сан, 2019.- 192х.- ISBN 978-99978-763-5-5.



АНУ-д Монгол судлалыг үндэслэгчдийн нэг, нэрт эрдэмтэн Оуэн Латтимор нь анх 1929 онд Өвөр Монголын Жирмэн аймаг, Хөлөнбуйрт ирж байхдаа

Монголыг сонирхож, улмаар судлах хүсэлдээ автан 1944 онд АНУ-ын дэд ерөнхийлөгчтэй цуг анх удаагаа Монгол улсад ирсэн ба үүнийхээ дараа АНУ-ын Балтиморын Жон Хопкинс их сургуульд Дилэв хутагт, Гомбожав, Өргөнгөө Онон нарыг урин ирүүлж, Монгол судлалыг эхлүүлж байсан түүхтэй. Түүний энэ бүтээлд нүүдэлчин Монголчуудын ахуй амьдрал, хувьсгалын удирдагч Д.Сүхбаатарын үйл хэрэг, хувьсгалын дараах үеийн нийгмийн амьдрал, Чойбалсангийн засаглалын жилүүд, хүнд хэцүү үе ба хөгжил, өөрчлөлтийн цаг үеийг гадны судлаачийн нүдээр харснаа тэмдэглэн өгүүлжээ.

63.3(1)

Л 266

/НХУУТ-6, ОУХНУС-1/

ЭШФ Т-23543-23545

Монгол судлалын өгүүллүүд = Abticles on mongolian studies / Эрхлэн хэвл. Ж.Баясах, Ж.Урангуа; Эх бэлт. А.Төмөр-Очир.- УБ.: Монлойс, 2019.- 2019х.- ISBN 978-9919-22-841-5.



МОНГОЛ СУДАЛАЛЫН
ӨГҮҮЛЛҮҮД

Энэхүү бүтээлд Монголын түүх, монгол судлалд хамаарах зарим асуудал болон Хятад-Монголын харилцааны түүх, Өвөр Монгол дахь Монгол түүх судлалын тойм, Монголын Энэтхэг судлалын тойм зэрэг түүх бичлэгийн талаар хийгдсэн судалгааны нэлээд олон өгүүллүүд багтсан байна. өгүүллүүдийг давхар тусгажээ. Мөн түүхч Хэрээд Л.Жамсрангийн товч намтар, бүтээлийн жагсаалтыг эмхэтгэлд оруулжээ.

63.3(1)

М 692

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т-23619-23623

Монголоо гэсэн эрдэмтний өв: Мэндэлсний 90 насны ойд энэхүү номоо зориулав: Сурвалжлан цуглуулж тэмдэглэсэн Л.Жамсран / Эмхт. Ж.Урангуа; Хян. Д.Базардорж; Эх бэлт. М.Лхамжав.- УБ.: Монлойс, 2019.- 298х.- ISBN 978-9919-22-774-6.



Энэхүү номыг түүхч Л.Жамсрангийн цуглуулсан аман түүхийн өв болон түүний өдрийн тэмдэглэлээс түүвэрлэн бүтээжээ. Тус ном "Сурвалжилсан тэмдэглэлүүд", "Л.Жамсрангийн өдрийн тэмдэглэлийн хэсгээс" гэсэн үндсэн хоёр бүлэгтэй. Эхний бүлэгт "Намын дээд сургуулийн хоёр жилийн сургуулийн сонсогчид 1964-1967 онд сурвалжилсан тэмдэглэлүүд" ба "Дарьгангачуудын түүхэнд холбогдох нутгийн уугуулуудын яриа" хэмээх хоёр хэсгээс бүрджээ. Мөн Л.Жамсран өөрийн биеэр Дарьганга нутгийн настнуудтай ярилцсан ярианы тэмдэглэл зэрэг нийт 155 тэмдэглэл багтаасан байна.

63.3(1)

М 692

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т-23624-23628

Нанхиад сурвалж дахь монголын түүхэнд холбогдох ойлбор = Collected Chinese sources for mongol history / Эрхл. Д.Заяабаатар; Орч. Д.Ундрах; Ред. Ц.Цэрэндорж; Хэвлэлд бэлт.

Э.Жаргалмаа; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 196х.- ISBN 978-9919-504-15-1.

Тус бүтээлд Монгол-Мингийн харилцааны түүхэнд холбогдох сурвалжийн эмхэтгэлийн тэргүүн дэвтрээс 6 сурвалжийг орчуулж, эх бичиг, түүхийн судалгааны тайлбарыг хийсэн бөгөөд эртний хятад хэлээр бичсэн энэхүү сул шастир бичгүүдийг анх удаа монгол хэлээр орчуулан тайлбар хийсэн нь дараа дараагийн судлаачдад гарын авлага, эх хэрэглэгдэхүүн болох чухал ач холбогдолтой юм.



63.3(1)

Н 288

/НХУУТ-7, ГНОФ-8/

ЭШФ Т-23708-23710

Пүрэвдорж Г. **Засагт хан аймгийн сэцэн сартуул хошуу** / Хян. Г.Цэрэнханд; Эх бэлт. П.Номинцэцэг; Хавтасны диз. Э.Доржханд.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 224х.- (Ховд Их Сургууль-Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль).- ISBN 978-9919-22-696-1.



Энэхүү нэгэн сэдэвт бүтээлд Халхын Засагт хан аймгийн Сэцэн сартуул хошууны түүхийг XVI зууны үеэс 1920-оод оны дунд үе хүртэлх хугацааг хамруулан судалсан судалгааг нэгтгэн дүгнэж, түүхэн баримтуудын хамт тусгажээ. Түүнчлэн Гэрсэнз жалайр хун тайжийн үеэс түүхэнд тэмдэглэгдсэн Сартуул отог хошуу болон тэлж томорсон түүх болон сартуул угсаатны зүйн асуудлыг тусгайлан судалж үзсэн байна.


63.3(1)

П 915

/НХУУТ-5/

ЭШФ Т-23716-23718

Сэцэн сартуул хошуу: Түүхэн баримтууд-I / Монгол бичгээс хөрв. Г.Пүрэвдорж; Хян. Г.Дашням, Да.Эрдэнэбат; Эх бэлт. О.Болор; Хавтасны диз. Б.Батцэрэн.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 136х.- (Ховд Их Сургууль-Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль).- ISBN 978-99978-52-64-9.



Тус бүтээлд Сартуулын Сэцэн засгийн хошууны түүх, хошуу ноёдын угсаа, залгамжлал, хошууны түүхэн газар зүйн асуудал, засаг захиргаа, нийгэм эдийн засгийн байдал, хүн амын тоо, шилжилт суурьшил, овгийн бүрэлдэхүүн, хэл, угсаа, сэтгэл судлалын онцлог зэрэг олон сонирхолтой материалыг эмхэтгэсэн байна. Түүнчлэн Манж Чин Улс болон Монгол улсын түүхийн баримт бичгүүдэд тэмдэглэгдсэн Халхын Засагт хан аймгийн Сэцэн сартуул хошуутай холбогдох баримт бичгүүдийг монгол бичгээс кирилл үсэгт буулган хэвлүүлжээ.

63.3(1)

С 987

/НХУУТ-4/

ЭШФ Т-23719-23721

Сэцэн сартуул хошуу: Түүхэн баримт, судалгаа-II / Эмхт. Г.Пүрэвдорж; Хян. Г.Цэрэнханд; Хавтасны диз. Э.Доржханд.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 240х.- (Ховд Их Сургууль. Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль).- ISBN 978-99978-870-1-6.



Эл эмхэтгэлд Халхын Засагт хан аймгийн Сэцэн сартуул хошууны нутгийн засаг захиргааны (цэс, өргөх бичиг, зар зурхай, тэмдэгт бичиг, зарлан тушаасан зэрэг, мэдүүлсэн бичиг, мэдүүлсэн илгээсэн хэрэг заргын бичиг, захидал, илгээсэн бичиг, цэс дэвтэр) түүхэн баримт бичгүүдийг Олноо өргөгдсөн Монгол улсын үеийн түүхэнд холбогдох эх сурвалж бичгээс кирилл үсэгт хөрвүүлэн буулгаж, тайлбар хийхийн сацуу хошууны газрын зураг болон сартуулын түүх судлалд холбогдох гадаад, дотоодын хэвлэлд нийтлэгдсэн 14 өгүүллийг оруулсан байна.


63.3(1)

С 987

/НХУУТ-4/

ЭШФ Т-23722-23724

Долгормаа Г. **Ховдын тувачууд:** Дурсамж, зан заншил, соёл, уламжлалт үг хэллэг, толь бичиг / Эрхлэн хэвл. На. Сүхбаатар; Цувралын ред. Б.Түвшинтөгс; Ботийн ред. Б.Адъяа.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 316х.- (Түүх соёл, хэл бичиг судлалын Тод номын гэрэлт төв: Bibliotheca oiratica-Biography serica Цувр. 12).- ISBN 978-99978-713-1-2.



Энэхүү номыг 1943 онд Алтайн нурууг хойш даван нүүдэллэж, одоогийн Буянт голын сав нутагт суурьшсан Тувачуудын аман түүх, дуртгал дурсамж дээр тулгуурлан бүтээсэн. Үүнд Ховдын тувачуудын уламжлалт зан үйл, ёс заншил, соёл урлаг, аман зохиол, бэлгэдэлт үгс зэрэг тэдний амьдрал ахуй, соёлтой холбоотой нэршил, үг хэллэгийг багтаасан байна.

63.5(1)

Д 466

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т-23686-23690

Халхын Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны хүн, малын тооллого: 1923: Одоогийн Архангай аймгийн чулуут, Өндөр-Улаан, Ихтамир, Булган сум / Ред. С.Амарбаяр; Хөрв. Ч.Батдорж.- УБ.: Удам соёл, 2019.- 352х.- ISBN 978-9919-21-573-6.

Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны засаг захиргааны бүтэц, газар нутгийн зохион байгуулалт, хүн ам ба малын данс мөн Шива Ширээт хутагтын шавийн хүн, амын данс бүртгэлийг архивын баримтаас кирилл үсэгт хөрвүүлэн эмхэтгэж судлаач уншигч, сонирхогчдод зориулан хүргэж байна.

63.5(1)

Х 197

ЭШФ Т- 23852



ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Менежментийн шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь = Glossary of management science terminology: Монгол-Англи-Орос-Уйгаржин монгол / Г.Батхүрэл, Д.Энх-Отгон, Я.Шуурав ба бус.; Зөвлөх. Ч.Ундрам, Я.Шуурав; Редакцийн зөвлөл Я.Шуурав, Г.Батхүрэл, Ц.Цэцэгмаа ба бус.; Монгол хэлний ред. О.Шинэбаяр, Г.Гэрэлмаа; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Эмхт. М.Золбоо; Хавтасны диз. Ч.Амарзаяа.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 300х.- (МУИС).- ISBN 978-9919-504-19-9.



Тус бүтээлд менежментийн удирдтгал, төлөвлөлт, зохион байгуулалт, манлайлал, хяналт, хүний нөөцийн менежмент, инноваци, ба өөрчлөлтийн удирдлага, удирдлагын мэдээллийн систем гэсэн 8 үндсэн бүлэг, 18 дэд сэдвийн хүрээнд менежментийн ухааны сургалт, судалгаа, болон практикт түгээмэл хэрэглэгддэг 1200 орчим нэр томъёог тайлбарлажээ. Энэ нь монгол хэл дээр хэвлэгдэн гарч буй менежментийн ухааны анхны тайлбар толь бөгөөд удирдахуйн ухаанаар суралцагчид, судлаачид, сонирхогч өргөн олон уншигчдад зориулагдсан болно.

65.290-2я2

М 442

ЭШФ Т-23814-23818

Наранхүү Л., Чинзориг Н. **Үйл ажиллагааны менежмент.**- УБ.: Арвайбархан, 2020.- 526х.- ISBN 978-9919-22-872-9.



Энэхүү сурах бичигт үйлдвэрлэл, үйлчилгээг үр ашигтай зохион байгуулахад чиглэсэн менежментийн орчин үеийн тулгамдаж байгаа асуудлуудын талаар шийдвэр гаргахад хэрэглэгдэх энгийн аргуудаас гадна эдийн засаг математик загварчлалын аргууд, мэдээллийг компьютер дээр боловсруулах аргачлалуудыг нэмж оруулсны дээр сэдэв бүрээр нэр томъёоны тайлбар өгч, мэдлэг шалгах асуултууд, ажиллах бодлого дасгалуудыг оруулжээ.

65.290-2

Н 294

/НХУУТ-7, БС-3/

ЭШФ Т-23571-23573

Оюунцэцэг Л. **Үндэсний инновацийн тогтолцоо бүрдүүлэх онол, практикийн асуудлууд:** Нэг сэдэвт бүтээл (монограф) / Ред. Т.Дорж; Техник ред. М.Заяа, М.Бурмаа; Эх бэлт. М.Бурмаа, Т.Сүмжидмаа; Хавтасны диз. Б.Мандухай, Д.Бүжин.- УБ., 2019.- 386х.- (ШУТИС. Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль).- ISBN 978-9919-21-970-3.



Энэхүү бүтээлд инноваци, түүнтэй холбоотой гол ойлголт, категориудын мөн чанар, агуулга, ангилал, инновацийн процесс, үйл ажиллагаа, инновацийн салбар түүний хүрээнд явагдах интеграцын үйл явц тэр дундаа Монгол улсын хувьд дэлхий дахины энэхүү

нийтлэг чиг хандлагыг харгалзан хөгжлийнхөө бодлого стратегийн хүрээнд инновацийн чиг баримжааг тусган бодитойгоор хэрэгжүүлэх мөн үндэсний инновацийн тогтолцоо, экосистем бүрдүүлж хөгжүүлэх асуудлыг онол арга зүй болоод практик арга туршлага талаас нь тусгажээ.

65.9(1)

О 634

/НХУУТ-5, БС-2/

ЭШФТ-23552-23554

Хироно Р. **Макро эдийн засгийн бодлого, менежментийн асуудлууд** / Эмхт. Я.Шуурав; Эх бэлт. М.Энхтуул.- УБ.: Номтпресс, 2019.- 92х.- (Удирдлагын академи-Менежментийн тэнхим).- ISBN 978-99978-4-396-8.



Тус бүтээлд макро эдийн засгийн удирдлага, менежментийн үндсэн асуудлуудыг багтаасан. Мөн доктор Рёокичи Хироногийн анхны цуврал лекцүүд, түүнчлэн УБХ, ХҮЯ дээр хийсэн уулзалтын материал, 1993 оны 3 дугаар сард Удирдлагын Хөгжлийн Институт багш, сонсогчдод уншсан товч лекцийн тэмдэглэлийг нэгтгэн оруулжээ. Энэхүү товхимолыг эрдэмтэн судлаач, оюутан суралцагч, аж ахуйн удирдагч, улс төрчдөд зориулав.

65.290-2

Х 366

/НХУУТ-4, ГНОФ-3, БС-2/

ЭШФ Т-23555-23557

Хэрлэн Б. **Удирдах эв дүй.**- УБ.: Арвай бархан, 2020.- 272х.



Удирдах албан тушаалтны үүрэг, удирдлага ба манлайлал, стресс менежмент, шийдвэр гаргах ур чадвар, хүмүүсийн урам зоригийг бадраах, идэвхижүүлэх ур чадвар, баг бүрдүүлэн удирдах ур чадвар, зөрөлдөөнийг зохицуулан удирдах ур чадвар, дэмжиж харилцах ур чадвар, эрх мэдэл нөлөөгөө тэлэх, ашиглах зэрэг менежерийн ур чадваруудын тухай ойлголт, онолын тайлбарыг сорил, дүн шинжилгээ, практик дасгалын хамт тус номонд тусгажээ.

65.050.2

Х 916

/НХУУТ-3, ГНОФ-3, БС-1/

ЭШФ Т-23725-23727

Хэрлэн Б., Вагнер Д. **Хүний нөөцийн удирдлага:** Гарын авлага / Ред. Д.Цэрэндорж; Орч. Б.Хэрлэн; Диз. Х.Мөнхцэцэг.- УБ.: Арвайбархан, 2020.- 94х.- ISBN 978-99929-988-5-7.



Хүний нөөцийн удирдлагын онолын орчин үеийн үзэл баримтлалууд, үндсэн функцүүд, тэдгээрийг хэрэгжүүлж буй хөгжингүй орнуудын бодит жишээ, туршлагыг энэхүү гарын авлагад түлхүү оруулсан байна. Тус бүтээл нь хүний нөөцийн удирдлага, ялангуяа төрийн байгууллага дахь хүний нөөцийн удирдлагыг сонгон судалж байгаа багш, судлаач, оюутан суралцагч болон удирдах ажилтан, менежерүүдэд зориулав.

65.290-2

X 916

/НХУУТ-5, БС-2/

ЭШФ Б-29836-29838

Хэрлэн Б., Вагнер Д. **Өөрчлөлтийн удирдлага**: Гарын авлага / Ред. Д.Цэрэндорж; Орч. Б.Хэрлэн; Диз. Х.Мөнхцэцэг.- УБ.: Арвайбархан, 2020.- 81х.- ISBN 978-99929-832-0-5.



Энэхүү сургалтын гарын авлагыг ХБНГУ-ын Подстамын их сургуулийн профессор Д.Вагнер боловсруулж түүнийг тус академийн багш Б.Хэрлэн монгол хэлнээ орчуулсан байна. Тус номонд өөрчлөлтийн удирдлагын онолын үзэл баримтлалууд, өөрчлөлтийн стратегиуд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл явц, учрах саад тотгорыг гэтлэх арга замын талаар тусгасан бөгөөд аливаа байгууллага нэг төлөв байдлаас нөгөөд шилжих үйл явцыг удирдлагаар хангах буюу өөрчлөлтийн удирдлагыг судалж буй судлаач, оюутан суралцагсад зориулжээ.

65.290-2

X 916

/НХУУТ-5, БС-2/

ЭШФ Б-29839-29841

Японы ногоон хөгжлийн туршлага / Ред. Ц.Баатар; Хэвлэлд бэлт. У.Загдцэсэм.- УБ.: Тод бичиг, 2017.- 273х.- ISBN 978-99978-1-189-9.



"Японы хөгжлийн бодлогын судалгаа, ногоон эдийн засгийн салбар дахь Монгол Японы хамтын ажиллагаа" сэдэвт ажлын хүрээнд Япон улсад эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчны асуудлыг тэнцвэртэй авч үзэж ирсэн туршлагыг эдийн засгийн хөгжлийн үе шатуудад хэрэгжүүлсэн бодлого, ногоон инновацийн чиг хандлага, байгаль экологи, эрчим хүч, агаар, ус, хөрс, хог хаягдлын салбарын болон хот төлөвлөлт, экологийн аялал жуулчлал, байгаль орчны боловсролын чиглэлээр хийсэн судалгааны үр дүнг энэхүү хамтын бүтээлд тусгажээ.

65.28

Я 701

/ОУХНУС-1/

ЭШФ Б-29828-29829

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН

Миног К. **Улс төр: Тун товчхон танилцуулга = Politics: A very short introduction** / Орч. Т.Ариунсанаа; Техник ред. Б.Болдбаатар, В.Уянга; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 120х.- ISBN 978-9919-500-31-3.



Тус бүтээлд эртний сонгодог эринээс XX зуун хүртэлх хугацаанд улс төр хэрхэн хувьсан өөрчлөгдөж хөгжсөнийг тэнцвэртэйгээр тайлбарлахыг зорьжээ. Эхлээд Герер, Ромын сонгодог эринийг авч үзэн иргэншил, иргэн

гэж хэнийг хэлэх, эх оронч үзэл гэж юу болохыг тайлбарлажээ. Дараагийн бүлэгт Христийн шашин ба хувьч үзэл, орчин үеийн төр, хүчний тэнцвэр, улс төрийн идэвхи, намууд, үзэл номлол, ардчилал, үзэл суртал болон ХХI зуунд улс төр ямар байж болох талаар дурьдсан.

66.1(0)

М 561

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б 29775-29777

Теодулу Стэлла З., Рой Рави К. **Төрийн захиргаа: Тун товчхон танилцуулга** / Орч. Т.Ариунсанаа; Техник ред. Б.Болдбаатар, В.Уянга; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 116х.- ISBN: 978-99978-51-50-5.



Даяаршлын эринд төрийн захиргаанд тулгамдаж буй том сорилтуудын талаарх практик үзэл хандлагууд ба төрийн үйлчилгээний хувьчлал, тагнуул, тандалт зэрэг маргаантай асуудлуудыг товч тайлбарлаж, мөн төрийн захиргааны үүсэл, хөгжил, цаашид хэрхэн хувьсан хөгжиж буй талаар өгүүлжээ.

66.2

Т 359

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б-29772-29774

Монгол улсын төрийн байгуулал дахь засаглалын институтын талаарх судалгаа: Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж / Хян. Ц.Ганболд, А.Цанжид, О.Машбат ба бус.- УБ.: Мөнхийн үсэг.- 2018.- 165х.- (Конрад-Анденауэр Сан. МУИС. ШУС. Улс төр судлалын тэнхим)



Монгол улсын төрийн байгуулалт, засаглалын чиглэлээр академик түвшний судалгаа, шинжилгээнд суурилан хийгдсэн эрдэмтэн, багш судлаачдын оюуны бүтээлийг уншигч та бүхэнд толилуулж байна. Энэхүү судалгааны эмхэтгэлд МУ-ын парламент, ерөнхийлөгч ба гүйцэтгэх засаглалын институтийн байр суурь, эрх мэдлийн хэрэгжилтийн шинжилгээ, бодлогын зөвлөмж, экспертүүдийн багийн танилцуулга оржээ.

66.3(1)12

М 692

/НХУУТ-3/

ЭШФ Т-23767-23768

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь: Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж / Хян. Ж.Төртогтох, П.Амаржаргал, С.Ганзаяа.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 239х.- (Конрад-Анденауэр-Сан. МУИС-ШУС-Улс төр судлалын тэнхим)



ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн Улс төр судлалын тэнхимийн харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд бодлогын судалгааны экспертүүдийн хамтарсан судалгааны үр дүн, тайланг уншигч та бүхэнд толилуулж байна. Тус судалгааны бүтээлд

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны талаарх судалгаа; нутгийн удирдлага дахь Засаг даргын эрх, чиг үүргийн харьцуулал; баг хорооны эрх зүйн байдал: асуудал шийдэл; хот тосгоны удирдлагын тогтолцоо, эрх зүйн байдлыг сайжруулахад тулгамдаж буй асуудал; орон нутгийн тогтвортой хөгжил-оролцогч талууд; орон нутаг дахь иргэдийн оролцоо; дараах асуудлуудыг хамарсан болно.

66.3(1)12

М 692

/НХУУТ-4, ХЗС-3/

ЭШФ Т-23769-23771

Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа: Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж / Экспертийн зөвл. Ж.Төртогтох, Ц.Ганболд, Й.Фурманн, ба бус.; Зөвл. Ш.Батсүх, Н.Бурмаа, П.Амаржаргал; Хян. Ж.Төртогтох, П.Амаржаргал, С.Ганзаяа.- УБ.: Сэлэнгэ пресс, 2020.- 255х.- (Конрад-Анденауэр-Сан. МУИС-ШУС-Улс төр судлалын тэнхим)



ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн Улс төр судлалын тэнхимийн харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд бодлогын судалгааны экспертүүдийн хамтарсан судалгааны үр дүн, тайланг толилуулж уншигч та бүхэнд толилуулж байна. Тус судалгааны бүтээлд олон нийтийн хэвлэл мэдээллийг улс төрөөс хараат бус байлгах нь; улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлс; монгол улсын төсвийн хяналт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам; монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам; засаглалын цахим шилжилт; монгол дахь ардчиллын бэхжилт, сорилтын зарим асуудлыг олон улсын харьцуулсан судалгааны үүднээс авч үзэх нь; дараах асуудлуудыг хамарсан болно.

66.3(1)6

М 692

/НХУУТ-7, ГНОФ-5, ХЗС-5/

ЭШФ Т-23772-23774

Мэйхуа Лань. Цэдэнбалын үеийн Монгол, Хятадын харилцаа: 1952-1984.- УБ.: ТЭПЭ., 2019.-145х.- ISBN 978-9919-22-990-0.

Энэхүү бүтээлд Ю.Цэдэнбалын засаглалын үеийн Гадаад Монгол ба Коммунист Хятад хоёр улсын харилцаанд анализ хийж, Гадаад Монголын тухайн цаг үеийн хөгжил, мөн Гадаад Монгол нь Коммунист Хятад, ЗХУ гэсэн эсрэгцсэн хоёр хүчний хооронд хэрхэн оршин тогтнож байв? Хятад, ЗХУ-ын харилцаа нь Гадаад Монголд болон Хятадын хөгжилд хэрхэн нөлөөлөв? Гадаад Монголын хувьд идэвхгүй гадаад бодлого явуулахаас өөр сонголт байсан уу? зэрэг асуултуудад хариулт өгөхийг зорьжээ.

66.4

М 94

/НХУУТ-5, ОУХНУС-1/

ЭШФ Т-23567-23570



SIRPA FORUM: Бүс нутгийн хамтын ажиллагаа ба Монгол улс: Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл №3 / Ерөн. ред. С.Баттулга; Эмхт. Б.Мөнх-Өлзий, С.Оюунсүрэн, Г.Баасанжав.- УБ.: Удам соёл, 2020.- 566х.- ISBN 978-9919-504-20-5.



Уг эмхэтгэлд Монгол улсын хоёр хөрш болон гуравдагч хөршийн харилцаа, гадаад бодлого, аюулгүй байдал бүс нутгийн геополитикийн шинэ навигаци ба Монгол улсын газарзүйн байршлын геостратеги, зөөлөн хүч"-ний бодлого эдийн засаг, нийгмийн харилцаа, нийтийн удирдлагын хөгжил, иргэдийн оролцоо зэрэг асуудлын хүрээнд тулгарч буй зангилаа асуудлууд, сорилт болон шинэ чиг хандлагын талаар эрдэмтэн судлаачдын тавьсан илтгэлүүд орсон ажээ.

66.4

S 36

/НХУУТ-2, ОУХНУС-5/

ЭШФ Т-23759-23761

ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН

Батбаяр Б., Цэдэвсүрэн М. **Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх:** Тойм лавлагаа, харьцуулсан судалгаа, дүн шинжилгээ = History of the amendments to the constitution of Mongolia.- УБ., 2019.- 158х.- ISBN 978-99978-899-5-9.



Тус эмхэтгэлийн нэгдүгээр хэсэгт монголчуудын өмнөх тогтолцоонд дагаж мөрдсөн 1924, 1940, 1960 оны Үндсэн хууль болон 1992 оны ардчилсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан түүхийн асуудлыг хөндөж, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн тойм лавлагаа, харьцуулсан судалгаа, хоёрдугаар хэсэгт Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд хийсэн дүн шинжилгээ мөн дагаж мөрдсөн дөрвөн үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг тусгасан энэхүү бүтээлийг Үндсэн хуулийг сонирхон судлагч хэн бүхэнд танилцуулах зорилготой болно.

67.400.1

Б 332

/НХУУТ-2, ХЗС-5/

ЭШФ Т-23731-23733

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын үндсэн хууль.- УБ., 2019.- 88х.



Германы ард түмэн Үндсэн хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэн баталсан Үндсэн хуульд Баден-Вюрттемберг, Бавари, Берлин, Бранденбург, Бремен, Хамбург, Хессен, Мекленбург-Форпоммерн, Доод Саксони, Умард Райн-Вестфален, Райнланд-Пфальц, Саарланд, Саксони, Саксони-Анхальт, Шлезвиг-Хольштайн болон Тюринген муж улсын германууд өөрийн чөлөөт сонголтоороо Герман улсын эв нэгдэл, эрх чөлөөг бүрэн тусгаж чадсан энэхүү Үндсэн хууль нь Германы нийт ард түмэнд хүчин төгөлдөр үйлчилнэ гэжээ. Энэхүү хуулийн эмхэтгэлийг олон улсын эрх зүйн судлаач, суралцагсад болон сонирхон уншигч хэн бүхэнд зориулав.

67.400(4Гер)

X 425

/ОУХНУС-5/

ЭШФ Т-23740-23742

Парламент: Судалгааны эмхэтгэл: Боть ХХХ / Хян. Д.Бадамдаш, Д.Халиун; Эмхт. Д.Жигваангүнсэл; Эх бэлт. Г.Баатар.- УБ.: Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх, 2020.- 395х.- ISBN 978-99978-915-8-7.



Тус цуврал судалгааны эмхэтгэлд дэлхийн улс орнуудын эдийн засаг, нийгэм, эрх зүй, төрийн байгуулалын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын хөгжил, шинэчлэл, туршлагыг харьцуулан судалсан судалгааны тайлангууд орсон байна.

67.400.6

П 183

/ХЗС-2/

ЭШФ Т-23775-23776

Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэл.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 256х.- ISBN 991995313-X.



Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлийн эмхэтгэлд “Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн нөхцөл байдал: хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн зарим асуудал”, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт”, “Химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалтын талаар тулгамдаж буй зарим асуудал”, “Хүний эрхийн олон улсын индекс ба Монгол Улсын эзлэх байр” гэсэн үндсэн 4 сэдвийн хүрээнд хийгдсэн судалгааны илтгэл, өгүүлэлүүд оржээ.

67.400.7(1)

М 692

/ХЗС-2/

ЭШФ Б-29850-29852

Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Шүүхийн практик / Зөвл. А.Бямбажаргал; Багийн ахлагч Р.Мөнхзул; Судлаачид Д.Баяр, Д.Бадамцэцэг, С.Билгүүн.- УБ.: Би Си Ай, 2020.- 104х.- ISBN 978-9919-9574-3-8.



Уг бүтээлд ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн хэрэгжилтийн өнөөгийн бодит байдлыг тусгаж улмаар цаашид боловсронгуй болгох асуудлыг энэхүү судалгаагаар авч үзсэний дээр судалгааны баг ЗХШХШТХ-ийн 18.3-т заасан дөрвөн үндсэн агуулга бүхий нийтийн ашиг сонирхлын хүрээнд эдүгээ хянан шийдвэрлэгдсэн бүхий л тохиолдол, энэ төрлийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн, шинжилгээг багтаажээ.

67.401

Н 615

/ХЗС-5/

ЭШФ Т-23777-23779

Алтан-Очир М. **Хорих ял эдлүүлэх дэглэм = Prison regima strafvollzugs regime = Режим отбывания лишения свободы:** Орчин цагийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба

байгуулагдсаны 100 жилийн ойд зориулав / Ред. Ж.Амарсанаа, Н.Гантулга, Д.Уранчимэг; Хавтасны диз. М.Гүнбилэгт.- УБ.: Голден легион, 2020.- 204х.- ISBN 978-99919-23-517-8.



Судлаач энэхүү бүтээлдээ Монгол улсын ялын тогтолцоон дахь хорих ялын гүйцэтгэх үүрэг, эрх зүйн түүхэн уламжлалыг Монголын эртний төрт улс Хүннү, Их монгол улс, Юань гүрнээс эхлэн Манжийн ноёрхолын үеийн хорих ял, Олноо өргөгдсөн Монгол Улсын үеийн хорих ял, Хэмжээт эрхт хаант Монгол улсын үеийн хорих ял ба орчин цагийн Монгол улсын шүүх засаглалын хорих ялын тогтолцоог бүхэлд нь авч үзсэн байна. Мөн хорих ял эдлүүлэх дэглэмийн олон улсын эрх зүйн зохицуулалт, баримт бичиг, гадаадын зарим орны хорих ял эдлүүлэх дэглэмийн онцлог, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, түүнд хийсэн дүн шинжилгээ, өнөөгийн тулгамдсан асуудал мөн цаашид анхаарах асуудлыг нэгтгэн дүгнэсэн чухал ач холбогдолтой бүтээл болно.

67.408

А 486

/НХУУТ-4, ГНОФ-3, ХЗС-10/

ЭШФ Т-23734-23736

Нарангэрэл С.,Эрдэнэбулган Ж. **Монгол улсын эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж:** Нэгэн сэдэвт бүтээл / Эх бэлт. Т.Золбоо; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 297х.- ISBN 978-99978-69-36-4.



Тус хамтын бүтээлд зохиогчид МУ-ын Эрүүгийн хуулийг төгөлдөржүүлэх асуудлыг хөндсөн байна. Монгол Улсын Эрүүгийн хуулийн үзэл баримтлал, зарчим, хуулийн тогтолцоо, хуулийн нэр томьёо ба найруулга, гэмт хэргийн бүрэлдэхүүн, ялын тогтолцоо зэрэг эрүүгийн хуулийн зүйл заалтуудад зохиолчийн зүгээс санал зөвлөмжөө шигтгэн эл бүтээлийн холбогдох зүйлд томьёолсон байна. Түүнчлэн улс орныхоо эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны болон эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, залгамж чанарыг огт алдагдуулах ёсгүй, гадны хуулийг хуулбарлаж болохгүй гэсэн чухаг санааг тусгажээ.

67.408(1)

Н 294

/НХУУТ-7, ХЗС-20/

ЭШФ Т-23691-23693

Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ: Эмхэтгэл / Эмхт. Ц.Гантулгат; Хян. Г.Эрдэнэбат; Эх бэлт. Б.Чулуунбат.- УБ., 2020.- 368х.- (Монголын криминологичдын холбоо).- ISBN 978-991923428-1.



Энэхүү эмхэтгэлд МУ-ын Их хурлаас баталсан 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн " Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдийг Эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэгтгэсэн ба хавсралтаар уг нэмэлт, өөрчлөлтүүдийг өмнөх хуулийн зохицуулалттай нь харьцуулах байдлаар хүснэгт хэлбэрт оруулан тусгасан байна. Мөн

эрүүгийн хууль тогтоомжид тусгагдсан хууль зүйн ойлголтуудыг практикт зөв хэрэглэх үүднээс Улсын дээд шүүхээс хэрэг, маргааныг шийдвэрлэх тайлбарласан үндэслэлүүдийг холбогдох тогтоолуудаас хэсэгчлэн оруулж, нэмэлтээр дээрх эрүүгийн хууль тогтоомжид орсон нэр томъёонуудын тайлбарыг салбарын бусад хуулиудаас түүвэрлэн эмхэтгэжээ.


67.408

Э 807

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23728-23730

Садовникова М.Н. ба бус. **Шүүхэд шударга ёсыг тогтоох загварыг нэвтрүүлэх арга зүйн зөвлөмж:** Практикт суралцагч нарт зориулсан гарын авлага / М.Н.Кровушкина, Э.Л.Раднаева; Ред. А.Н.Шестакова; Орч. Б.Эрдэнэбаяр.- Эрхүү, 2015.- 160х.- ISBN 978-5-9624-1285-6.



Шүүхийн үйл ажиллагаанд эвлэрүүлэн зуучлах аргыг ашиглах боломж ба үйл ажиллагааны журам, эвлэрүүлэн зуучлал нь маргааныг шийдвэрлэх хувилбаруудын нэг болох талаар болон насанд хүрээгүй хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэхэд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх журам, онцлогийн талаар, түүнчлэн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг санаачлах, хэрэгжүүлэх зэрэг ойлголтын агуулгыг жишээ тайлбартайгаар тусгажээ.

67.71

С 167

/ХЗС-20/

ЭШФ Б-29816-29818

ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Батбаяр Ц. **Халхын голын дайн ба их гүрнүүдийн геополитик:** Улс төр-дипломатын түүх: 1935-1941 он / Хян. С.Чулуун; Диз. Ц.Амартүвшин.- УБ.: Бэмби сан, 2019.- 240х.- ISBN 978-9919-21-948-2.



Япон-манжийн цэрэг 1935 оны 1 сард БНМАУ-ын уугуул нутаг Халхын сүмд байрладаг хилийн заставыг эзлэн авсанаар Монгол, Манжгогийн "хилийн будлиан" гэгч үүсэж, улмаар 1939 оны Халхын голын дайнд хүргэсэн түүхтэй. Халхын голын цэрэг-дайны ажиллагаа 1939 оны 5 сараас 9 сард болж өнгөрсөн боловч Халх голын дайныг тойрсон их гүрнүүдийн геополитик, улс төр-дипломатын үйл ажиллагаа 1935-1941 онуудад өрнөсөн гэсэн түүхийн шинэ гаргалгааг хийж, тэрхүү улс төр-дипломатын түүхийг Монгол, Орос, Японы архивын баримт бичиг дээр тулгуурлан бичсэн анхны бүтээл болно. 1935-1937 онд хэд хэдэн үе шаттай болсон Монгол, Манжгогийн Бага хурал, Халхын голын дайн дууссаны дараа БНМАУ, Манжгогийн хилийг нарийвчлан тогтоох зорилгоор 1939-1941 онд Чита, Харбин хотуудад ээлжлэн болсон БНМАУ, ЗСБНХУ, Япон, Манжго дөрвөн этгээдийн хэлэлцээрийн талаар архивын баримтад түшиглэн нилээд тодорхой өгүүлжээ.

68.9

Б 332

/НХУУТ-3, ОУХНУС-1/

ЭШФ Б-29794-29795

Цэдэв П. **Гамшгаас хамгаалах төлөвлөлт**: Сурах бичиг / Хян. О.Үржин, Б.Баатарсүрэн; Эх бэлт. Ч.Самбууням; Хавтасны диз. А.Нямлхагва.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 352х.- ISBN 978-99978-3-819-3.



Уг бүтээлд гамшгаас хамгаалах төлөвлөлтийн ойлголт, шинж чанар, гүйцэтгэх үүрэг, үндсэн зарчим, төрөл ангилал ба үе шатууд, байгууллагын зорилго ба төлөвлөгөөний түвшин, гамшгаас хамгаалах арга хэмжээ, удирдлага, бэлэн байдлын төлөвлөлт, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хийх ерөнхий аргачлал, байгууллага /аж ахуй нэгж, компани, хуулийн этгээд /-ын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хийх ерөнхий аргачлал, сум /дүүрэг/, аймаг, нийслэл, гамшгаас хамгаалах Улсын албадын төлөвлөлт гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах аргачлал, гамшгийн үед хүн амыг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийн талаар тусгажээ.

68.9

Ц 939

/НХУУТ-3, ХЗС-5/

ЭШФ Т-23550-23551

Карие Д, Паул Е. **Ази-Номхон далайн аюулгүй байдлын нэр томьёоны тайлбар толь** / Англи хэлнээс орч. Ч.Улаанхүү, Ш.Болдбаатар; Орч. ред. Ч.Улаанхүү, Ш.Болдбаатар; Эх бэлт. Б.Даваа.- УБ.: Шидэт өнгө, 2018.- 200х.- ISBN 978-99978-3-598-7.



Энэхүү толь бичигт хамтын ажиллагаа аюулгүй байдлын олон талт асуудлууд, аюулгүй байдлын асуудлаар шинээр хэрэглэгдэж байгаа хэллэг, томьёоллыг оруулж өгчээ. Уг толь бичгийн ач холбогдол нь практикийн болоод онолын хоёр талтай байна. Мөн Бодлого боловсруулагчид хийгээд улс төр судлаачид аюулгүй байдлын үйл хэрэгт мэдлэгтэйгээр оролцоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой аж.

68.9я2

К 23

/НХУУТ-6, ОУХНУС-1/

ЭШФ Т-23643-23645

СОЁЛ СУДЛАЛ

Ундармаа Н. **Олон улсын харилцааны соёл, ёс зүй = International communication culture and etiquette** / Хян. Т.Баянсан; Эх бэлт. Б.Болор; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 272х.- ISBN 978-99929-4-227-7.



Уг номонд нийт 73 улс үндэстнийг хамруулсан бөгөөд тэдгээр хүмүүсийн онцлог шинж болон мэндлэх хүндлэх ёс, нэрийн хуудас солилцох, хооллох соёл, бэлэг солилцох уламжлал, хувцаслалт, үгэн ба үгэн бус харилцааны хэлбэр, ажил хэргийн уулзалт, хэлэлцээрийн ёс журам, олон улсын утсан харилцааны ёс зүй, дуут мессэж, автомат хариулагч ба факс хэрэглэх соёл, и-мэйл бичих соёл гэх зэрэг албан ба албан бус

харилцаанд баримтлах соёл болон гадаад оронд явахад эмэгтэйчүүд юу анхаарах асуудлуудын талаар зөвлөсөн байна.

71.05(0)

У 365

/НХУУТ-4, ГНОФ-3, ХЗС-5/

ЭШФ Б-29825-29827

ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ

Эрдэм шинжилгээний бичиг = Scientific journal: №12(526) / Эрхл. Т.Энх-Амгалан; Дугаар эрхл. Л.Золжаргал.- УБ.: МУИС пресс, 2020.- 144х.- (МУИС-Эрдэнэт Сургууль).- ISBN 978-99973-4-269-0.



МУИС-ийн Эрдэнэт Сургуулиас эрхлэн гаргасан тус эрдэм шинжилгээний бичиг нь "Бизнесийн удирдлагын салбар", "Хэлний боловсрол" гэсэн хоёр үндсэн бүлэгтэй бөгөөд Эрдэнэт Сургуулийн эрдэмтэн багш нарын эрдэм шинжилгээний хамтарсан бүтээл, өгүүлэлүүд багтжээ.

72

Э 739

/ЛавФ-1/

ЭШФ Т-23747-23749

МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг: Физик №30 (527) / Зөвлөлийн дарга Ж.Даваасамбуу; Нарийн бичгийн дарга Г.Эрдэнэ-Очир.- УБ.: МУИС-ийн хэвлэх, 2020.- 98х.- (МУИС. ШУС. Физикийн тэнхим).- ISSN 2311-1097.



МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулиас эрхлэн гаргадаг энэхүү эрдэм шинжилгээний бичигт эрдэмтэн багш нарын физик, химийн чиглэлээр хийсэн эрдэм шинжилгээний хамтарсан бүтээл, судалгааны өгүүлэл, илтгэлүүд багтсан байна.

72+22.3

М 692

/ЛавФ-1/

ЭШФ Т-23753-23755

МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг: Газарзүйн асуудлууд = Journal of geographic issues: №19/1 / Ред. Д.Амартүвшин; Техник ред. Д.Ганпүрэв.- УБ.: МУИС пресс, 2019.-134х.- ISSN 2312-8534.



МУИС-ийн ШУС-ийн Газарзүйн тэнхимээс эрхлэн гаргадаг тус эрдэм шинжилгээний бичигт эрдэмтэн судлаачдын газар зүй, газар ашиглалт, газар зохион байгуулалтад хийсэн судалгааны өгүүлэл, илтгэлүүд багтжээ.


72+26.8

Г 161

/ЛавФ-1/

ЭШФ Т-23744-23746

МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг №513 (38): Түүх XVII = Historia Mongolarum / Эрхл. Э.Жигмэддорж.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 216х.- ISSN 2224-1804.



МУИС-ийн ШУС-ийн хүмүүнлэгийн ухааны салбарын түүхийн тэнхимээс эрхлэн гаргаж буй энэхүү эрдэм шинжилгээний бичигт доктор, профессор эрдэмтэн багш нарын бүтээл болох эрдэм шинжилгээний өгүүллүүдийг багтаажээ.

72+63

Э 739

/НХУУТ-2, ЛавФ-1/

ЭШФ Т-23762-23764

МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг №17 (505): Политологи / Эрхл. Ж.Төртогтох; Нарийн бичгийн дарга Ц.Батболд; Техник ред. Т.Есүхэй.- УБ.: МУИС пресс, 2019.- 120х.- (МУИС. ШУС. Нийгмийн ухааны салбар).- ISSN 2227-6904.



МУИС-ийн Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг "Политологи" эрдэм шинжилгээний бичгийн энэхүү дугаарт тухайн салбарын судлаачдын Монголын улс төрийн түүхийн зарим эх сурвалжид хийсэн судалгааны илтгэл өгүүллүүд оржээ.


72+66

Э 739

/НХУУТ-3, ЛавФ-1/

ЭШФ Т-23756-23758

МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг №22 (531): Боловсрол судлал. УБ., 2019.- 56х.- ISSN 1818-8478.



Тус бүтээлд ЕБС-ийн үнэлгээний бодлогын түүхчилсэн судалгаа, Рашын загвар, хичээлийн төлөвлөлтийг объектив үнэлэх боломж, МУИС-ийн оюутны сэтгэл ханамжийн судалгаанд хийсэн шинжилгээ зэрэг материалууд багтжээ. ЕБС-ийн суралцагчдын мэдлэг чадварын үнэлгээний талаарх зарим бодлогын түүхчилсэн судалгааг хийхдээ 1911 оноос хойш батлагдан гарсан боловсролын тухай хууль, тогтоомж, дүрэм, эрх зүйн болон бодлогын баримт бичгүүд, 1936-2018 оны хооронд ЕБС-ийн сургалтад мөрдөж байсан болон одоо мөрдөж буй нийт 7 үнэлгээний журмыг дэлгэрэнгүй судлан тусгасан байна.

72+74.202

Б 553

/НХУУТ-3, ЛавФ-1/

ЭШФ Т-23750-23752

Монгол судлалын чуулган: Эрдэм шинжилгээний сэтгүүл: №29(64) / Эрхл. С.Хөвсгөл, Ж.Батбаатар, Ц.Өнөрбаян ба бус.- УБ.: Жиком пресс, 2020.- 235х.- (МУБИС. Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль).- ISBN 978-99973-44-52-6.

МУБИС. Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургуулийн энэхүү эрдэм шинжилгээний сэтгүүлд монгол хэл шинжлэл, уран зохиол судлал, аман зохиол, соёл судлалын чиглэлийн судлаачдын судалгааны илтгэл өгүүллүүд, мөн Ардын билигзүйч Д.Дашдоржийн 90 насны ойд зориулсан ЭШХ-ын илтгэлүүд (2019-11-29) тус тус орсон байна.

72+81.2М

М 692

ЭШФ Т-23765-23766



БОЛОВСРОЛ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН

Эрдэнэсан Д., Цэрэнчимэд Л. **Монгол хэл бичгийн олимпиад, шалгалтад бэлтгэгчдэд тусламж** / Ред. Д.Соронзон; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 272х.- ISBN 978-9919-23-130-9.



Тус гарын авлагад ЕБС-ийн монгол хэл бичгийн хичээлийн хөтөлбөрт тусгасан агуулгаар эзэмшсэн мэдлэг, чадвараа бататгах, эх хэлнийхээ баялаг сангаас суралцахын сацуу төрөл бүрийн эхэд суурилсан задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, сэтгэлгээний чадвар сорьсон даалгавруудыг багтаасан байна. ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчид болон МХУЗ-ын багш, мэргэжлийн ангийн оюутанд зориулав.

74.2я7

Э 739

/НХУУТ-5/

ЭШФ Б-29802-29804

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ. СЭТГҮҮЛ ЗҮЙ

Батсүх Ш. **Ярилцлага, сурвалжилга** / Диз. С.Даш-Очир; Хавтасны зур. Э.Бадрах; Хавтасны диз. А.Мөнхдөл.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 347х.- ISBN 978-9919-22-385-4.



Зохиогч эл бүтээлийнхээ эхний хэсэгт хэвлэлд өгсөн өөрийн ярилцлагуудаасаа нийтлэг шинжтэйг нь түүвэрлэж 14 ярилцлага оруулсан. Эдгээр нь зохиогчийн өөрийн үзэл бодол гэхээс илүү мэргэжлийн мэдлэг, ажлын туршлага, судалгааны үр дүнд тулгуурласан нийгэм, улс төр, засаг захиргаа, удирдлага, сэтгэл зүй, газрын харилцаа зэрэг өргөн хүрээтэй асуудлуудыг хамарсан байна. Номын хоёрдугаар хэсэгт "Төрийн захиргаа", "Газрын харилцаа" сэтгүүлийн эрхлэгчээр ажиллах хугацаандаа өөрийн болон гадаад орны улс төрчид, төрийн өндөр албан тушаалтнууд элчин сайдууд, их дээд сургуулийн профессорууд зэрэг янз бүрийн ажил мэргэжлийн хүмүүстэй хийсэн 17 ярилцлага сурвалжилгаа оруулжээ.


76.01

Б 34

/НХУУТ-6, ОУХНУС-1/

ЭШФ Б-29819-29821

Монголын шилдэг нийтлэл: Цуврал 99: Сүхбаатар аймаг "Талын түрлэг" бүлгэмийн сэтгүүлчдийн бүтээлийн цоморлог / Ерөн. ред. Т.Баасансүрэн; Зөвлөлийн гишүүд Д.Сарангэрэл, М.Зулькафиль, Б.Пүрэвдаш ба бус.; Нарийн бичгийн дарга До.Чулуунбаатар; Зөвл. Л.Түдэв, Ц.Дашдондов, Б.Лигдэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 412х.- ("Талын түрлэг" төрийн бус байгууллага).- ISBN 978-99973-2-329-3.



“Монголын шилдэг нийтлэл” цувралын 99 дүгээр ботид Төрийн шагналт, яруу найрагч О.Дашбалбарын “Мөнхийн бүтээлүүд мөхлийн ирмэг дээр” нийтлэлээс эхлээд СГЗ Ай.Төмөр-Очирын “Адууны тусгаар тогтнол”, Ц.Дашдондовын “Хэвлэл, мэдээллийн хэл найруулгын алдаа мадаг хэтийдлээ”, Г.Мэнд-Ооёогийн “Нутаг сэлгэх хунгийн энэлэн буюу Дарьгангын дууль” зэрэг шилдэг бүтээл багтжээ. Мөн сэтгүүлч, улстөрч Т.Гандигийн “Аавын нутгийг эргэхүй”, сэтгүүлч С.Амартайван, Г.Ариунчулуун, Г.Баатарнум, Б.Номин нарын 40 гаруй уран бүтээлчийн “Уулын тунгалаг голуудаар умдаалсан тэмдэглэл”, “Улаанбаатар хот хэмээх “Нинжа”-гийн сургууль”, “Өмнөд Суданы өнгөт бус амьдрал”, “Үүлийн үйлийн үр” зэрэг бүтээл багтсан байна.

76.01(1)

М 695

ЭШФ Б-29861-29862

Наранчимэг М. **Монголын шилдэг нийтлэл:** Цуврал 98: "Монголын нууц товчоо"-г шинжлэн судлахуй / Ерөн. ред. Т.Баасансүрэн; Зөвл. Л.Түдэв, Ц.Дашдондов, Б.Лигдэн; Нарийн бичгийн дарга До.Чулуунбаатар; Зөвлөлийн гишүүд Д.Сарангэрэл, М.Зулькафиль, Б.Пүрэвдаш ба бус.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 304х.- ISBN 978-99973-2-329-3.



Монголын шилдэг нийтлэл” цувралын 98-р ботийг уншигч та бүхэнд толилуулж байна. Тус бүтээлд улс төр, удирдахуйн ухаан, дипломат харилцаа, цэрэг стратеги, эдийн засаг, зан заншил, ёс суртахуун, шашин шүтлэг гээд олон шинжлэх ухааны асуудлыг багтаасан тул олон салбарын эрдэмтэн мэргэдийн судалгаа шинжилгээний талбар, судлагдахууны эх үүсвэр болсон байна.

76.01(1)

Н 294

ЭШФ Б-29859-29860

Рагчаасүрэн Ө. **Монголын шилдэг нийтлэл:** Цуврал 91: Эсээний галерей / Ерөн. ред. Т.Баасансүрэн; Зөвл. Л.Түдэв, Ц.Дашдондов, Б.Лигдэн; Нарийн бичгийн дарга До.Чулуунбаатар; Зөвлөлийн гишүүд Д.Сарангэрэл, М.Зулькафиль, Б.Пүрэвдаш ба бус.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 304х.- ISBN 978-99973-2-329-3.



Монголын шилдэг нийтлэл” цувралын 91-р ботийг уншигч та бүхэнд толилуулж байна. “Эсээний галерей” нэртэй энэхүү боть нь Монгол Улсын Соёлын Гавьяат зүтгэлтэн сэтгүүлч Өвгөнхүүгийн Рагчаасүрэнгийн шилмэл нийтлэлүүдээс бүрджээ. Тус боть

нь уран зургийн эсээ, хөрөг таталбар, гэрэл зураг, нийтлэл тэмдэглэл, зураасан зураг гэсэн зургаан бүлэгтэй. Эдгээр бүлэг бүр нь боловсрол, соёл, урлаг, сэтгүүлзүй, өнгөрсөн, одоог илтгэх гэрэл зураг, хөрөг нийтлэл, зэрэг олон бүтээл орсон 80 гаруй хувь нь Дархан хотод ажиллаж амьдарч буй алдартнуудын тухай өгүүлсэн байна.

76.01(1)

P 148

ЭШФ Б-29857-29858

Рэнчинханд И. **Ромын хамба намайг ер үнсэж байгаагүй** / Ред. Б.Оюунчимэг; Эх бэлт. Б.Ариунаа.- УБ.: Бэмби сан, 2020.- 376х.- ISBN 978-9919-23-125-5.



Энэхүү бүтээлд 60 гаруй улсын 100 гаруй хүний талаар өгүүлжээ. Тэдний дотор нийгмийн бараг бүх давхаргын хүмүүс багтсан. Хаан, хатан, ханхүү, хун тайж, гүнж, улс төрч, олон улсын нэр хүнд бүхий байгууллагын тэргүүн, түүнд нэр дэвшигч, бизнес эрхлэгч, эрдэмтэн, судлаач, сэтгүүлч, тамирчин, дуучин, жүжигчин, эх орны дайнд оролцож явсан ахмад дайчин, гэрэл зурагчин, ядуу хүү, тэр ч бүү хэл зартай алан хядагч, ийм байгууллагын толгойлогчийн тухай ч бий.

76.01

P 398

/НХУУТ-7/

ЭШФ Т-23737-23739

Чулуун Р. **Монголын шилдэг нийтлэл**: Цуврал 68: Анхдагч / Ерөн. ред. Т.Баасансүрэн; Ред. Д.Данзан; Зөвл. Л.Түдэв, Ц.Дашдондов, Б.Лигдэн; Нарийн бичгийн дарга До.Чулуунбаатар; Зөвлөлийн гишүүд Д.Сарангэрэл, М.Зулькафил, Б.Пүрэвдаш ба бус.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 296х.- ISBN: 978-99973-2-329-3.



"Монголын шилдэг нийтлэл" цувралын 68 дугаар ботийг уншигч та бүхэнд толилуулж байна. "Анхдагч" нэртэй энэхүү ботид 47 хүний тухай өгүүлсний дийлэнх ихэнх нь монголын анхны роман "Алтайд"-ыг бичсэн агуу Ч.Лодойдамба, бөхчүүдээс тодорсон анхны эрдэмтэн генерал Ж.Авхиа, Олимпын анхны аварга Н.Түвшинбаяр, олимпын анхны мөнгөн медальт эмэгтэй тамирчин О.Гүндэгмаа, чөлөөт бөхийн анхны дэлхийн хүрэл медальт бүсгүй Ц.Энхжаргал зэрэг үнэхээр анхдагчдын талаар өгүүлсний дээр түмний танил болсон Говь-Алтайн хөх харчуудын тухай, бас эх орныхоо нэрийг дэлхий, олимпын дэвжээнд цуурайтуулсан алдарт тамирчдын тухай дурджээ.

76.01(1)

Ч 891

ЭШФ Б-29855-29856

НОМЫН САН СУДЛАЛ

Номын сан, мэдээллийн байгууллагад мөрдөх стандартын эмхэтгэл: Монгол улсын стантарт: Албан хэвлэл.- УБ.: Стандартчилал хэмжил зүйн газар, 2020.-180х.

Стандартчилал, хэмжил зүйн газар (цаашид СХЗГ гэх) нь Олон улсын стандартчиллын бодлогыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг байна. Энэ стандарт нь өмнөх "Баримт бичиг-Монгол кирил цагаан толгойн үсгүүдийг романчилах" MNS 5217:2003 стандартыг хүчингүй болгож орлоно. Номын сан, мэдээллийн байгууллагад мөрдөх энэхүү стандартын эмхэтгэлд монгол кирил үсгийн латин хөрвүүлэг, ном хэвлэлийн бүтээгдэхүүн ба аудио видео материал, нотны хэвлэл, газрын зургийн ном зүйн бичилтийн стандарт, баримт бичгийн бичлэгийн алдааг засварлах тэмдэг, Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага, Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлагыг тус тус стандартчилж өгсөн байна.



78ц

Н 728

/Лав-1/

ЭШФ Т-23536-23539

ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Азжаргал М. **Монгол хэлний ярианы дадал I:** Монгол хэлний багц сурах бичиг / Ред. Ү.Зайжөн; Эх бэлт. Ч.Амарзаяа.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 72х.- ISBN 978-9919-23-322-8.



Монгол хэлний ярианы дадал I сурах бичиг нь монгол хэл сурч буй хятад хүнд зориулагдсан ба тодруулбал, Жилиний гадаад хэлний их сургуулийн Дорно дахины хэлний сургуулийн монгол хэлний мэргэжлийн нэгдүгээр ангийн Монгол хэлний яриа хичээлд зориулсан хэрэглэгдэхүүн болно. Уг сурах бичгийн агуулгаар дамжуулан монгол хэлний ярианы анхан шатны чадварыг эзэмшээд зогсохгүй монголчуудын өдөр тутмын ахуй амьдрал, соёлтой холбоотой ярианы үг хэллэгээс суралцана. Уг бүтээл нь шинэ үг хэллэг, дүрмийн тайлбар, нэмэлт үг хэллэг болон нэмэлт мэдээлэл, дасгалуудаас бүрдэнэ.

81.2М-96

А 34

/НХУУТ-3/

ЭШФ Т-23796-23797

Азжаргал М. **Монгол хэлний ярих дадал II:** Монгол хэлний багц сурах бичиг / Ред. Ү.Зайжөн, Б.Нэргүйжаргал; Эх бэлт. Ч.Амарзаяа.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 100х.- ISBN 978-9919-23-323-5.



Монгол хэлний ярианы дадал II сурах бичиг нь монгол хэл сурч буй хятад хүнд зориулагдсан ба тодруулбал, Жилиний гадаад хэлний их сургуулийн Дорно дахины хэлний сургуулийн монгол хэлний мэргэжлийн нэгдүгээр ангийн Монгол хэлний яриа хичээлд зориулсан хэрэглэгдэхүүн болно. Уг сурах бичгийн агуулгаар дамжуулан монгол хэлний ярианы анхан шатны чадварыг эзэмших төдийгүй монголчуудын өдөр тутмын ахуй амьдрал, соёл холбоотой ярианы үг хэллэгээс суралцана. Уг бүтээл нь шинэ үг хэллэг, дүрмийн тайлбар, нэмэлт үг хэллэг болон нэмэлт мэдээлэл, дасгалуудаас бүрдэнэ.

81.2М-96

А 34

/НХУУТ-3/

ЭШФ Т-23798-23799

Бямбажав Х. **Тод үсгийн сурах бичиг** / Эрхлэн хэвл. На.Сүхбаатар; Цувралын ред. Б.Түвшинтөгс; Ботийн ред. Г.Ядамжав; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 128х.- (Bibliotheca oiratica: Цувр. 81).- ISBN 978-99978-713-3-6.



Энэхүү сурах бичгийг тод үсэг сурах, судлах хүмүүст зориулсан бөгөөд бүтцийн хувьд шинэ тутам үзэх үсэг, түүнийг нүдлэн тогтооход зориулсан унших, хуулан бичих, галиглах, хөрвүүлэх дасгал, дүрмийн тайлбар тэргүүтнээс бүтнэ. Сурах бичгийг ашиглах талаар анхаарах хэдэн зүйл буй. Үүнд: Сэдэв бүрд буй нүдлэн тогтоох, унших, хуулан бичих дасгалыг алгасахгүй хийх, Тод үсгийн үндсэн махбод зурлагыг сурах бичигт зургаар үзүүлсэн дарааллын дагуу бичих дасгалыг зүгширтлээ давтан бичих, Цагаан толгойн задгай үе үсгүүдээ сурсны дараагаар дан ба давхар дэвсгэр үеэр үе, үг бүтээж бичих, унших дасгалыг байнга хийх, Тод үсгийг латинаар галиглах, латин галигаас тод үсэгт хөрвүүлэх дасгалуудыг давтан хийсээр сурах, Тод бичгийн зөв бичих дүрмийг баримталсан эх бичвэрүүдийг оруулсан тул зөв бичлэгийг тогтоож авахаас гадна бие даан бичиж, хөрвүүлж сурахдаа уг сурах бичигт орсон дүрэм болон тод үсгийн толь бичиг унших бичгүүдийг ашиглах хэрэгтэй.

81.2Мя7

Б 984

/НХУУТ-5, ГНОФ-8/

ЭШФ Т-23646-23650

Бямбажав Х. **Тод үсгийн толь бичиг** / Эрхлэн хэвл. На.Сүхбаатар; Цувралын ред. Б.Түвшинтөгс; Ботийн ред. Г.Ядамжав; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 216х.- (Bibliotheca oiratica: Цувр. 82).- ISBN 978-99978-713-2-9.



Зохиогчид энэхүү толь бичгийг бүтээхдээ бусад толь бичгүүдийг ашиглахаас гадна тод бичгийн эхэн үеийн дурсгалууд болох Зая бандидын орчуулгын зохиол, сурвалжийн эх бичгүүдийг ашиглан үгсийн санг үүсгэж боловсруулсан. Эдгээр үгийн санг цуглуулахдаа уг үгийн зөв бичлэгийг тодорхой болгон нутлахын тулд тод үсэг зохиогдсоны даруйхан бичигдсэн сурвалжууд, ялангуяа Зая бандидын орчуулсан ном судрууд, түүний хойно Зүүнгарын Галданцэрэн хааны үед барлагдсан тод бичгийн дурсгалуудаас сонгон авч зөв бичлэгийг тулган үзээд ийнхүү XVII зуунд үсэг зүй, зөв бичих зүйн хувьд тогтсон тод бичгийн зөв бичих зүйн журмыг баримтлан жигдлэсэн ажээ.

81.2М-4

Б 984

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т-23651-23655

Гэрэлмаа Г. **Монгол хэлний нэр томьёо бүтэх нийлэг болон задлаг хэв шинж** = **Analytic and synthetic methods of creating terms in Mongolian** / Ред. Л.Болд; Техник ред. Б.Баяртуяа; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ., 2020.- 248х.- (Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолын Хүрээлэн. МУИС. Монгол судлалын хүрээлэн).- ISBN 978-9919-23-613-7.



Зохиогч энэ бүтээлдээ монгол хэлний үг бүтэх нийлэг болон задлаг арга нь нэр томьёо бүтээхэд ямар утга, үүрэгтэй оролцож буйг тодруулж, хэрэглээний давтамжийг нь Text Stat программаар тооцоолон гаргажээ. Ингэхдээ УНТК -оос хэвлүүлсэн Улсын нэр томьёоны комиссын мэдээ цуврал бичиг, Орос монгол нэр томьёоны толь (3 боть) болон өнөөдрийг хүртэл хэвлүүлээд буй салбар салбарын нэр томьёоны толь бичгүүдийг судалгааны хэрэглэгдэхүүн болгон ашиглажээ.

81.2М

Г 951

/НХУУТ-7, ГНОФ-8/

ЭШФ Т-23632-23634

Гэрэлт-Ирээдүй Б. **Анхан шатны монгол хэлний унших бичиг**: Монгол хэлний багц сурах бичиг / Ред. Ү.Зайжөн; Эх бэлт. Б.Үүрийнтуяа.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 124х.- ISBN 978-9919-23-440-9.



Энэхүү сурах бичиг нь Жилиний Гадаад хэлний их сургуулийн бүтээл бөгөөд тус сургуулийн Эрдэм шинжилгээний бүтээлийг дэмжих сангийн тусламжаар хэвлүүлсэн болно. Анхан шатны монгол хэлний унших бичиг нь монгол хэл сурч буй хятад хүнд зориулагдсан ба тодруулбал, Жилиний гадаад хэлний их сургуулийн Дорно дахины хэлний сургуулийн монгол хэлний мэргэжлийн ангийн Монгол хэлний унших дадал хичээлд зориулсан хэрэглэгдэхүүн болно. Уг бүтээл нь үндсэн ба нэмэлт бичвэртэй бөгөөд тэдгээр бичвэрт суурилсан шинэ үгс, тайлбар бататгах дасгалуудаас бүрдэнэ. Бичвэрүүд нь гол төлөв Монгол улс, монгол үндэстний соёл, ёс заншилтай холбоо бүхий агуулгатай бөгөөд суралцагчид багшийн тусламжтай болон бие даан уншиж ойлгох боломжтой.


81.2М-96

Г 952

/НХУУТ-3/

ЭШФ Т-23790-23791

Гэрэлт-Ирээдүй Б. **Дунд шатны монгол хэлний унших бичиг**: Монгол хэлний багц сурах бичиг / Ред. Ү.Зайжөн; Эх бэлт. Б.Үүрийнтуяа.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 160х.- ISBN 978-9919-23-441-6.



Энэхүү сурах бичиг нь Жилиний Гадаад хэлний их сургуулийн бүтээл бөгөөд тус сургуулийн Эрдэм шинжилгээний бүтээлийг дэмжих сангийн тусламжаар хэвлүүлсэн болно. Дунд шатны монгол хэлний унших бичиг нь монгол хэл сурч буй хятад хүнд зориулагдсан ба тодруулбал, Жилиний гадаад хэлний их сургуулийн Дорно дахины хэлний сургуулийн монгол хэлний мэргэжлийн

ангийн Монгол хэлний унших дадал хичээлд зориулсан хэрэглэгдэхүүн болно. Уг бүтээл нь үндсэн ба нэмэлт бичвэртэй бөгөөд тэдгээр бичвэрт суурилсан шинэ үгс, тайлбар бататгах дасгалуудаас бүрдэнэ. Бичвэрүүд нь гол төлөв Монгол улс, монгол үндэстний соёл, ёс заншилтай холбоо бүхий агуулгатай бөгөөд суралцагчид багшийн тусламжтай болон бие даан уншиж ойлгох боломжтой.

81.2М-96

Г 952

/НХУУТ-3/

ЭШФ Т-23792-23793

Зайжөн Ү. **Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй**: Монгол хэлний багц сурах бичиг / Ред. М.Азжаргал; Эх бэлт. Ч.Амарзаяа.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 186х.- ISBN 978-9919-23-324-2.



Энэхүү сурах бичиг нь Жилиний Гадаад хэлний их сургуулийн бүтээл бөгөөд тус сургуулийн Эрдэм шинжилгээний бүтээлийг дэмжих сангийн тусламжаар хэвлүүлсэн болно. Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй сурах бичиг нь монгол хэл сурч буй хятад хүнд зориулагдсан ба тодруулбал, Жилиний гадаад хэлний их сургуулийн Дорно дахины хэлний сургуулийн монгол хэлний мэргэжлийн хоёрдугаар ангийн Монгол хэлний хэлзүй хичээлд зориулсан хэрэглэгдэхүүн болно. Уг сурах бичиг нь дүрмийн тайлбар, жишээ дасгалуудаас бүрдэнэ. Мөн жишээ өгүүлбэрүүд нь гол төлөв монголын алдартай уран зохиолууд, сонины мэдээ зэргээс түүвэрлэжээ.

81.2М-96

3-16

/НХУУТ-3/

ЭШФ Т-23794-23795

Мөнх Н. **"Монголын нууц товчоон"-ы хүний нэрийн франц орчуулга** / Хян. Ц.Шагдарсүрэн.- УБ.: Удам соёл, 2020.- 117х.- ISBN 978-9919-23-460-7.



Уг ном нь франц хэлээр гарсан анхны бүрэн орчуулга бөгөөд 851 зүүлт тайлбар, бүлэг бүрийн франц хэлээрх товч агуулга бүхий 358 тал хуудастай томоохон бүтээл болно.

Мөн тус орчуулгад МНТ-ы хүний нэрийн судалгаа, Мари-Доминик Эвен, Родика Поп нарын МНТ-ы хүний нэрийн франц орчуулгын тухай дэлгэрэнгүй тусгажээ.


81.2-7

М 816

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Б-29847-29849

Тод үсгийн унших бичиг-I: Түүх соёл, хэл бичиг судлалын тод номын гэрэл төв / Хэвлэлд бэлт. Б.Түвшинтөгс; Эрхлэн хэвл. На.Сүхбаатар; Цувралын ред. Б.Түвшинтөгс; Ботийн ред. Б.А.Бичеев; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган. - УБ.: Соёмбо принтинг, 2019.- 240х.- (Bibliotheca oiratica: Цувр. 83).- ISBN: 978-99978-713-4-3.



Тод бичгээр тэмдэглэсэн хэдэн зуун жилийн түүхтэй утга зохиолын баялаг өв дэлхийн олон орны сан хөмрөг, хувь хүмүүст хадгалагдсаар буй тул тэдгээрийг судлах, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах зэрэг ажил тулгамдаж байна. Иймд манай төв үүсэн байгуулагдсан цагаасаа орчин үеийн судалгааны шаардлага, уншигчдын хэрэгцээнд нийцсэн, тод бичгийн сурах бичиг, толь бичиг, унших бичиг зохиох, цахим орчинд хэрэглэх үсгийн тиг бүтээхэд анхаарсаар ирсэн юм. Энэхүү зорилтын хүрээнд манай судлаачид Тод бичиг сурах бичиг, Тод үсгийн толь бичиг, Тод үсгийн унших бичиг-1, 2 гэсэн сургалт судалгааны цогц бүтээлийг олон жилийн судалгааны үр дүнд энэхүү дугаарт хэвлүүлж байна.

81.2М

Т 45

/НХУУТ-5, ГНОФ-8/

ЭШФ Т-23656-23660

Тод үсгийн унших бичиг- II: Түүх соёл, хэл бичиг судлалын тод номын гэрэл төв / Хэвлэлд бэлт. Б.Түвшинтөгс; Эрхлэн хэвл. На.Сүхбаатар; Цувралын ред. Б.Түвшинтөгс; Ботийн ред. М.Эрдэмт; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 220х.- (Bibliotheca oiratica: Цувр. 84).- ISBN: 978-99978-713-5-0.



Эрт үеийн мэргэдүүдийн тод үсгээр тэмдэглэн буулгаж үлдээсэн Бурхан Буддагийн сургаал номлол судар, үлгэрүүдийг орчин цагийн уншигч, судлаачдад зориулан эмхэтгэжээ. Хүмүүний итгэл, сэтгэл хоёр хоосон боловч ийм хий хоосны дунд итгэл бишрэл юунд тулгуурлахыг энэ номын агуулга илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл Итгэл бол Буддын шашинтан хүний сүсэг бишрэлийн үндсэн ухагдахуун юм. Энэ бол бурхан, ном, хувраг хэмээх гурван эрдэнэд итгэнэ гэсэн үг билээ. Ийнхүү нүгэл хилэнцийг цээрлэж, ирээдүйд учирч болох аюулаас сэргийлж, тэр аюулаас аврах зам нь Гурван эрдэнэд итгэх хэмээх үзлийг энэ сударт өгүүлдэг ажээ.

81.2М

Т 45

/НХУУТ-5, ГНОФ-8/

ЭШФ Т-23661-23665

Шинэбаяр О., Золжаргал Б. Адилтгалын аргаар бүтсэн монгол нэр томьёо=Mongolian terms greated by metaphorical method / Ред. Ж.Баянсан.- УБ., 2020.- 166х.- (ШУА. Хэл зохиолын хүрээлэн. МУИС. Монгол судлалын хүрээлэн).- ISBN 978-9919-23-636-6.



Энэхүү бүтээл нь тухайн ард түмний сэтгэлгээний онцлогийг илтгэх метафор буюу адилтгах аргаар нэр томьёо хэрхэн бүтэх зүй тогтол, агуулга, танин мэдэхүй, хэрэглээний учир холбогдлыг уламжлал, шинэчлэлийн хамааралд судлан байгаль, нийгэм, техник технологийн салбаруудын нэр томьёоны баялаг жишээгээр тайлбарлан таниулжээ. Тус гарын авлагыг метафор сонирхон судлагч эрдэмтэн судлаачдад зориулав.

81.2Мя2

Ш 663

/НХУУТ-7, ГНОФ-8/

ЭШФ Т 23629-23631

АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ

Дулам С. **Монгол домог зүйн дүр** / Ред. Д.Бум-Очир; Диз. Г.Самдан.- УБ.: Битпресс, 2020.- 340х.- (Монгол соёлын чуулган: Б.1)



Домог зүй бол тухайн зохиогдож байсан цаг үеийнхээ хүний ертөнцийн тухай үзэл төсөөлөл нь мөн болой. Хүй нэгдлийн үеийн хүний сэтгэлгээ нь бүхэлдээ домог зүйн сэтгэлгээ байсан юм. Иймд домог зүй гэдэг үг нь дэлгэрэнгүй утгаар бол зөвхөн ардын аман зохиолын нэг зүйлийг биш хүй нэгдлийн үеийн хүн төрөлхтний оюун сэтгэлгээг бүхэлд нь хэлдэг байна. Энэ утгаараа бол урлаг, шашин, гүн ухаан, ёс зүйн төсөөллийн аль нэгийг дангаар төлөөлөхгүй, харин хүний оюуны соёлын эл бүхий л салбарын үүсвэрийг хадгалсан нийтлэг сэтгэлгээ юм. Энэхүү судалгааны бүтээлд домог зүйн нэр томъёоны асуудал, домог зүйн сэтгэлгээ, домгийн гол өгүүлэмж, дүрүүд, бэлэгдэлт шинж талаас нь судлан тайлбарлажээ. Мөн байгаль, нар, сар, гариг эрхэс, уул ус болон хүний аж амьдралтай холбоотой олон домог яриаг энэ номноос унших боломжтой.

82.3(1)

Д 642

/НХУУТ-5, ГНОФ-6/

ЭШФ Т-23616-23618

Торгууд аман билгийн жишээ / Эрхлэн хэвл. Д.Ганболд, Д.Өрнөхгэрэл, И.Жавхлан; Ред. А.Батсуурь, М.Баавдай; Эх бэлт. Ц.Цэрэнханд, Б.Отгонбаяр, Ч.Амарзаяа; Хавтасны диз. Э.Доржханд.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 224х.- (Ховд их сургууль, Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль, Хэл зохиолын тэнхим).- ISBN 978-9919-23-188-0.



"Аман зохиол, аялгуу судлалын хээрийн дадлага"-аар Ховд аймгийн Булган сумын торгуудуудын дунд 1997, 2017 явж цуглуулсан хээрийн шинжилгээний эх материалд тулгуурлан "ТОРГУУД АМАН БИЛГИЙН ЖИШЭЭ" номыг бүтээжээ. Уг номонд торгууд хүмүүсийн хэлж ярьсан аман зохиолын төрөл зүйл болох үлгэр домог, дуу, ерөөл магтаал, зүйр цэцэн үг тэргүүтэн орсны дээр аж төрөх ёс, зан үйлийн талаарх үнэ цэнэтэй аман зохиолууд багтсан байна.

82.3(1)

Т 522

ЭШФ Т-23788-23789

УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ

Баасансүрэн Т. **Сономбалжирын Буяннэмэхийн уран бүтээл, бичлэгийн арга барил, сэтгэлгээний онцлогт хийсэн ажиглалт шинжилгээ** / Хян. До.Цэнджав, Л.Норовсүрэн, С.Байгалсайхан; Эх бэлт. Ц.Чагнаадорж; Техник ред. Ц.Чагнаадорж; Диз. П.Содбаатар.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 472х.- ISBN 978-9919-22-242-0.



МУСГЗ, сэтгүүлч, судлаач, доктор Т.Баасансүрэн “Сономбалжирын Буяаннэмэхийн уран бүтээл, бичлэгийн арга барил, сэтгэлгээний онцлогт хийсэн ажиглалт шинжилгээ” номоо уншигч та бүхэнд толилуулж байна. Тус бүтээл нь “Утга зохиолын судлал шинжилгээнд, “зохиолчийн лаборатори” буюу “зохиолчийн урлан судлалд” үнэ цэнтэй бүтээл болсон төдийгүй их дээд сургуулиудын сургалт, эрдэм шинжилгээний ажилд тулгуур гарын авлага болжээ.

83.3(1)

Б 109

ЭШФ Б- 29853-29854

Харьцуулсан уран зохиолын асуудлууд / Ред. С.Энхбаяр; Эх бэлт. Б.Баярбаатар.- УБ.: Жиком пресс, 2019.- 164х.- ISBN 978-9919-22-754-8.



Харьцуулсан утга зохиол судлал нь 21-р зууны уран зохиол судлалын тэргүүлэх чиглэл болж байна. Энэхүү бүтээлд монголын эртний болон орчин үеийн зарим зохиол бүтээлүүдийг ижил төстэй бусад бүтээл болон дүрүүдтэй харьцуулан судалсан эрдэмтэн судлаачдын судалгааны баримт материалууд оржээ.

83.3(1)


Х 262

/НХУУТ-3/

ЭШФ Б-29814-29815

УРАН ЗОХИОЛ

Батжаргал Д. **С+Н=247**: Сургуулийн дунд, өсвөр насныханд зориулсан тууж, өгүүллэгүүд / Ред. Л.Цэрэнжав; Диз. Ч.Эрхэмбаяр; Хавтасны зур. Ө.Золзаяа; УБ.: Бэмби сан, 2020.- 123х.- ISBN 978-9919-23-422-5.



Энэхүү бүтээлд гэнэн томоогүй хүүхдүүдийн санаанд орж болох сонин хачин, хүний ой тойнд ормооргүй таахын аргагүй оньсого таавар шиг зүйлүүдийн талаарх төсөөлөлд нь тулгуурлан төрөл бүрийн сэдвүүдийг хамруулжээ. Уг бүтээл нь амьдралын цэнхэр хаалгыг зүрхэлж ядан тогшиж буй хөвгүүд, охидод зориулав.

84-44

Б 335

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29808-29810

Гардоз П. **Үүр хаяарч байхад=Hajnali Laz (Fever at dawn)** / Орч. Б.Одгэрэл.- УБ.: Нэпко, 2019.- 204х.- ISBN 978-99978-5-183-3.


Петр Гардоз 1948 онд Будапешэд мэндэлжээ. Тэрээр театр, киноны хэд хэдэн шагналыг хүртсэн найруулагч юм. Өөрийн эцэг эхийн амьдралын бодит түүхээс сэдэвлэн өгүүлсэн "Үүр хаяарч байхад" зохиол нь түүний анхны роман ажээ.

84(4Унг)-44

Г 258

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29778-29780



Үмит А. **Истанбулын дурсгал** / Орч. М.Бямбасүрэн.- УБ.: Нэлко, 2019.- 556х.- ISBN 978-99978-5-184-0.



Туркийн орчин үеийн алдарт зохиолчдын нэг болох Үмит нь өөрийн эх орны өвөрмөц улс төр, түүхийн нөхцөл байдалд үндэслэн бичсэн энэхүү бүтээлдээ улс төрийн нууц явуулга, аллага, гэмт хэргийн талаар сонирхол татахуйц байдлаар тусгажээ. Тэрээр зохиол бичихдээ сайтар боловсруулсан дүрүүдийнхээ сэтгэл санаа, оюун бодолд гүн нэвтэрч чаддаг нууцлаг жанрыг төгс эзэмшсэн нь түүний бүтээлийг шилдэг борлуулалттай байлгаж чаддаг байна.

84(5Ту)-44

У 816

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29781-29783

70 жил, 70 зохиолч, 70 өгүүллэг: Хятадын шилдэг өгүүллэгүүд / Ред. Э.Гэрэлт; Эмхт. До.Болдхуяг; Эх бэлт. Б.Пүрэвдэлгэр; Хавтасны диз. С.Батжаргал.- УБ.: Ананд Гэрэл, 2019.- ISBN 978-9919-21-035-9.



Уг бүтээлд БНХАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Д.Ганхуяг тэргүүтэй манай редакцын зөвлөл Хятадын утга зохиолын яндашгүй баян өв сангаас шилдэг өгүүллэгүүдийг түүвэрлэн хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн түүхэн ойд зориулан хэвлүүлжээ. Эдгээр бүтээлд Хятадын утга соёлын гайхамшиг, Хятадын ард түмний аж амьдрал, зовлон жаргал, хүсэл мөрөөдлийн талаар тусган харуулсан бүтээлүүд орсон байна.

84(5Хят)-44

Б 547

Тэргүүн боть.-431х.

Дэд боть.- 428х.

ЭШФ Т-23786

ЭШФ Т-23787

УРЛАГ СУДЛАЛ

Батсайхан Ц. **Монголчуудын эрхэм өнгө, зохирол:** Монгол урлахуйн чуулган-1.- УБ.: ШУТИС хэвлэлийн газар, 2020.- 316х.- ISBN 978-9919-23-588-8.



Энэхүү бүтээлд улс үндэстнүүдийн уламжилж ирсэн өнгөний тухай ойлголт, бэлгэдэл тэр дундаа Монголчуудын өнгөний сонголт, хэрэглээний талаар өгүүлжээ. Өнгөний тухай ойлголт нь улс үндэсний соёлын дархлаанаас гадна тухайн үндэстний сэтгэл зүй, бие махбод, амьдралын ая тухад ч нөлөөлдөг учраас монголчуудын өнгөний бэлгэдэл, уламжлал болон мөн чанар, эрүүл мэнд, интерьер болон хувцас загварын ертөнцөд орших бүхий л өнгөний зохицол болоод өнгөний бүл тэдгээрийн онцлогийн талаар тус номонд тусгажээ.


85.12(1)

Б 341

/НХУУТ-7/

ЭШФ Т-23540-23542

Уран бүтээлчид: Амьдрал, бүтээл / Д.Локсли, Ж.Брэй, К.Баглэр ба бус.; Орч. Т.Ариунсанаа; Зөвл. Б.Болдбаатар; Ред. Д.Баярхүү, Б.Гэрлээ, Б.Нэргүй ба бус.; Диз. Н.Бямбацогт.- УБ.: Нэпко, 2019.- 360х.- ISBN 978-9919-500-14-6.



Сэргэн мандалтын эхэн үеэс өнөөг хүртэлх үеийн 80 гаруй аугаа уран зураач, барималчдыг алдаршуулан тайлбарласан энэ номонд тэдгээр уран бүтээлчдийн амьдрал, хайр сэтгэл, уран бүтээлүүдийг нь шинжлэн судалж тайлбарласан сонирхолтой баримтуудыг өгүүлжээ.

85.14(0)

У 457

/НХУУТ-7/

ЭШФ Т-23522-23524

Даваасүрэн Д. Бишгүүрийн аялгууны тэмдэглэгэ тайлах асуудалд / Зөвл. ред. Н.Жанцанноров, С.Дулам, Ц.Цэвэгсүрэн; Техник ред. П.Даваапил, Д.Түмэннаст.- УБ.: Линограф, 2020.- 130х.- (Соёл Урлагийн Их Сургууль).- ISBN 978-9919-501-13-6.



Зохиогч уг бүтээлдээ бишгүүр хөгжмийн нэр төрөл, хийц бүтээцээс авхуулаад бишгүүрийн аялгуу, бишгүүрдэх битүү амьсгаа, бишгүүрийн хуучин болоод шинэ аялгууны өвөрмөц эгшиг тэмдэглэгээг хүртэл холбогдох бүхий л эх сурвалжаас баримт цуглуулан түүнийгээ судлан шинжилж, орчин цагийн хөгжмийн онолын нэр томьёо, ойлголт ухагдахуунтай харьцуулан өөрийн дүгнэлтийг хийжээ.

85.31

Д 121

/НХУУТ-5/

ЭШФ Б-29833-29835

Энэбиш Ж. Архив амилж, дурсамж өрнүүлж, баримт хөврүүлж, өв бялхсан намтар: Хөгжмийн зохиолч Лувсанжамбын Мөрдоржийн мэндэлсэний 100 жилийн ойд зориулав / Ерөн. ред. Н.Жанцанноров; Ред. Ц.Пүрэвхүү; Ноотыг шивсэн Н.Нэргүй; Төслийн удирдагч М.Ундраа; Эх бэлт. Д.Наранбаатар, М.Дорждагва, Д.Оюун; Хавтасны зур. Д.Наранхүү.- УБ.: Адмон, 2019.- 258х.



Энэхүү 3 боть бүтээлд ХХ зууны Монголын мэргэжлийн хөгжмийн урлагийг үндэслэгч Лувсанжамбын Мөрдорж, Билэгийн Дамдинсүрэн, Сэмбийн Гончигсумлаа нарын намтрын хуудсыг сөхөж, ургийн түүхийг нээж, уран бүтээлийнх нь сонгодог туурвилуудаас дээжлэн оруулжээ.

85.319(1)

Э 665.

Б.1: Хөгжмийн зохиолч Лувсанжамбын Мөрдорж.- 258х.- ISBN 978-9919-22-673-2.

ЭШФ Т-23525-23527

Б.2: Хөгжмийн зохиолч Билэгийн Дамдинсүрэн.- 294х.- ISBN 978-9919-22-943-6.

ЭШФ Т-23528-23530

Б.3: Хөгжмийн зохиолч Сэмбийн Гончигсумлаа.- 2020.- 347х.- ISBN 978-9919-23-263-4.

ЭШФ Т-23531-23533

Энэбиш Ж. **Бүх нийтийн хөгжмийн боловсролын хөтөч:** Сурахуйн үүдэн, багшийн ном: Хүүхэд залуучуудын хөгжмийн гоо зүйн боловсролд зориулав / Ерөн. ред. Л.Дашням; Ред. Ц.Пүрэвхүү; Номыг шивсэн Н.Нэргүй; Эх бэлт. Д.Наранбаатар, М.Дорждагва, Д.Оюун; Хавтасны диз. Д.Наранхүү.-УБ.: Адмон, 2019.- 509х.- (МУШУА. Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн).- ISBN 978-9919-22-451-6.



Доктор Сономын Лувсанвандангийн нэрэмжит гоо зүйн дээд шагнал хүртсэн тус ном нь бүх нийтийн хөгжмийн боловсролын хөтөч болохын сацуу ЕБС-ийн хөгжмийн багш нарын гарын авлага, сургахуйн туслах материал болохыг уламжлалт сурган хүмүүжүүлэх зүйн үүднээс оновчтой зааж тодорхойлсон байна. Энэхүү бүтээлд эртний хөгжим судлалаас эхлээд монголд мэргэжлийн хөгжим үүсэж төлөвшсөн үе, орчин үеийн хөгжмийн чиг хандлага болон дуурь, балет, симфони, жүжиг, киноны хөгжим, морин хуурын тухай өгүүлэхийн сацуу домогт хуурч, бийч, дуучдын намтар, бүтээлийн өвийг сангийн тухай баримт материалууд багтсан байна.

85.319(1)

Э 665

ЭШФ Т-23558-23560

ШАШИН СУДЛАЛ

Далай лам XIV. **Нийтийн эрдэнэ дээрхийн гэгээн их дээд аврал итгэлт бээр хайрласан Нарогийн зургаан номын зарлигийн хөтөлбөр оршивой:** 1-р дэвтэр / Edit. Sermey Geshe Yangteng Rinpoche, Serje Geshe Ju-Thupga.- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Norbu Graphics, 2015.- 281х.- ISBN 978-93-82091-39-3.

86.35

Д 206

ЭШФ Т-23800



Далай лам XIV. **Дээрхийн гэгээн их аврал итгэлтийн нигуураас хайрласан сэтгэл ямагтын тайвширал бодь мөрийн зэрэг хураангуй утга тэргүүтний зарлигийн хөтөлбөр оршивой:** 2-р дэвтэр / Edit. Drepung Gomang Geshe Rabten Tulku, Sogan Tulku Pema Lodoe.- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Norbu Graphics, 2015.- 323х.- ISBN 978-93-83091-40-9.

86.35

Д 206

ЭШФ Т-23801



Далай лам XIV. **Нийтийн эрдэнэ дээрхийн гэгээн их дээд аврал итгэлт бээр хайрласан дунд бясалгалын зэргийн зарлигийн хөтөлбөр оршивой:** 3-р дэвтэр / Edit. Sermey Geshe Yangteng Rinpoche, Namda Thupten Yarphe.- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Norbu Graphics, 2015.- 173х.- ISBN 978-93-83091-41-6.

86.35

Д 206

ЭШФ Т-23802



Далай лам XIV. **Нийтийн эрдэнэ дээрхийн гэгээн их дээд аврал итгэлт бээр хайрласан Цогт-Очирт баатар нэг аюулгүйн үйлдэгчийн үүсгэл, төгсгөлийн зарлигийн хөтөлбөр оршивой:** 4-р дэвтэр: / Edit. Drepung Gomang Geshe Rabten Tulku, Serjey Geshe Ju-Thupga.- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Norbu Graphics, 2015.- 423х.- ISBN 978-93-83091-42-3.

86.35

Д 206

ЭШФ Т-23803



Далай лам XIV. **Ялгуусны тодорхой таалал:** Б.1: Ерөнхий номлол / Edit. Dagyab Kyabgön Rinpoche.- The Dalai Lama Trust Thekchen Choeling: Norbu Graphics, 2016.- 525х.- ISBN 978-93-83091-52-2.

86.35

Д 206

ЭШФ Т-23804



Далай лам XIV. **Ялгуусны тодорхой таалал:** Б.2: Цогт зөөлөн нигуурын иш / Edit. Dagyab Kyabgön Rinpoche.- The Dalai Lama Trust Thekchen Choeling: Norbu Graphics, 2016.- 611х.- ISBN 978-93-83091-52-2.

86.35

Д 206

ЭШФ Т-23805



Далай лам XIV. **Дээрхийн гэгээн их аврал итгэлтийн хүртсэн үсгийн хураангуй:** Эрдэнийн авшгийн хааны эрхи хэмээн үлдэх оршивой.- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Norbu Graphics, 2017.- 137х.- ISBN 978-93-83091-53-9.

86.35

Д 206

ЭШФ Т-23806



Далай лам XIV. **Их мутарлагийн үндэсийн тайлбар Гүрү-Иог, үнэнд барихын Намжилын соёл сэлтийн зарлигийн хөтөлбөр** / Edit. Rabten Tulku Tenzin Thegchok, Geshe Jigme Lodoe (Ex-IBD), Lobsang Wangden



Shastri Compilation, Lobsang Wangden Shastri.- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Archana, 2018.- 259х.- ISBN 978-81-937909-6-0.

86.35

Д 206

ЭШФ Т-23807

Далай лам XIV. **Бодь мөрийн зул, чадагчийн тодорхой таалал гурван санваарийг машид ангилах сэлтийн зарлигийн хөтөлбөр оршивой** / Edit. Yangten Tulku Lobsang Tenpe Gyaltzen, Lharampa Rongpo Lobsang Nyandak, Sogan Tulku Pema Lodoe.- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Archana India, 2018.- 171х.- ISBN: 978-81-937909-5-3.

86.35

Д 206

ЭШФ Т-23808



Далай лам XIV. **Дээдийн ном, чандмань эрдэнэ, эрдэнийн тонилхуйн Чингийн зарлигийн хөтөлбөр оршивой** / Edit. Yangten Tulku Lobsang Tenpe Gyaltzen, Lharampa Rongpo Lobsang Nyendak, Geshe Jigme Lodoe, Sogan Tulku Pema Lodoe, Lobsang Wangden Shastri.- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Archana India, 2018.- 225х.- ISBN 978-81-937909-4-6.

86.35

Д 206

ЭШФ Т-23809



Далай лам XIV. **Гүнсэн ламын нигуурын иш сэтгэл ямагтын тайвширал Бодийн санваарь өгөх 20-н санваарь тэргүүтний зарлигийн хөтөлбөр оршивой** / Edit. Rabten Tulku, Sogan Tulku Pema, Lobsang Wangden Shastri.- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Archana, 2018.- 485х.- ISBN 978-81-937909-3-9.

86.35

Д 206

ЭШФ Т-23810



Далай лам XIV. Их бодь мөрийн зарлигийн хөтөлбөр: 3 боть.- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Archana, 2018.- 789х.

86.35

Д 206

Б.1.-789х.- ISBN 978-81-937909-0-8.

ЭШФ Т-23811

Б.2.- 516х.- ISBN 978-81-937909-1-5

ЭШФ Т-23812



Б.3. Их төрөлхтний мөрийн зэргээс бясалгалын мөн чанар амирлан оршихуйд суралцах ёсон.- 609х.- ISBN: 978-81-937909-2-2.

86.35

Д 206

ЭШФ Т-23813

Далай лам XIV. **2004 онд дээд орон Цоо-Бадамд хайрласан бурхны шашны зарлигийн хөтөлбөр.**- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Sara bod kyi dbe skrun khang, 2015.- 61х.- ISBN: 978-93-83091-36-2.

86.35

Д 206

ЭШФ Б-29863



Далай лам XIV. **Эм зурхайн мөрийг үзүүлсэн сургаалын хураангуй оршивой** / Edit. Lharampa Rongpo, Lobsang Nyendak.- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Sara bod kyi dbe skrun khang, 2018.- 262х.- ISBN 978-93-83091-62-1.

86.35

Д 206

ЭШФ Б-29864



Далай лам XIV. **Мөрийн эрхэмийн зарлигийн хөтөлбөр хийгээд чухал хоёр зарлиг** / Edit. Yangten Tulku Lobsang Tenpe Gyaltzen, Lharampa Rongpo Lobsang Nyendak, Geshe Jigme Lodoe, Lobsang Wangden Shastri.- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Archana India, 2018.- 193х.- ISBN 978-81-937909-8-4.

86.35

Д 206

ЭШФ Б-29865



Далай лам XIV. **Бурханы шашны танилцуулга болон Билгүүний зүрхний зарлигийн хөтөлбөр** / Edit. Rabten Tulku Tenzin Thegchok, Geshe Jigme Lodoe, Lobsang Wangden Shastri.- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Archana, 2018.- 131х.- ISBN 978-81-937909-7-7.

86.35

Д 206

ЭШФ Б-29866



Далай лам XIV. **Дээрхийн гэгээн дээд их аврал итгэлт бээр байгаль орчин хийгээд асрал энэрэлийн замын үзүүлсэн зарлигийн хураангуй оршивой.**- Gaden Phodrang Trust Thekchen Choeling: Sara bod kyi dbe skrun khang, 2017.- 256х.- ISBN 978-93-83091-43-0.

86.35

Д 206

ЭШФ Б-29867



Далай лам XIV. **Бурханы шашны шинжлэх ухаан хийгээд үзэл бүгдийн хураангуй: 2 боть.**- Gaden phodrang trust: Norbu Graphics, 2014

86.35

Д 206



Б.1.- 531х.- ISBN 978-93-83091-25-6.

ЭШФ Б-29868

Б.2.- 582х.- ISBN 978-93-83091-24-9.

ЭШФ Б-29869

Лянхуан гурамсан судар / Орч. Т.Болдбаатар.- УБ.: Адмон, 2012.- 504х.- ISBN 978-99962-0-858-4.



Тус бүтээл нь буддын шашны их хөлгөний голлох судруудын нэг болох "Цагааан Лянхуа" хэмээх судрын орчуулга юм. Энэ орчуулга нь Кумаражива-гийн 406 онд санскрит хэлнээс хятад хэлрүү орчуулсан эхийг япон хэлнээ хөрвүүлэн уншдаг аргачлал дээр тулгуурлан монгол хэлнээ орчуулан буулгасан бүтээл ажээ. Энэ бүтээл нь буддын шашны үзэл санааг танин мэдэх, буддын уран зохиолтой танилцах, хэл шинжлэл эх бичиг судлалын үүднээс харьцуулан үзэж судлах тулгуур материал юм.

86.35

Л 974

ЭШФ Т-23826

Мөнхрөхүйн увидас / Санаачилж, ивээн тэтгэсэн Ж.Сандагдорж; Эрхлэн хэвл. Р.Ринчинбазар.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 312х.- (Увдисын шүтээн).- ISBN 978-9997-3-752-8.



Энэхүү номонд хүн төрөлхтний өмнө гайхамшигийг үзүүлж, анх оршоосон лагшин төлөвөө цаашид төнх байх мэт эдүгээг хүртэл хадгалсаар буй тойн эрдэнэ Ц.Чүлтэмжамц, аграмба Р.Санжаажав, хамба лам Д.Итгэл нарын тухай өгүүлэх болно. Тэдний лагшин төлөвт шилжсэн ижил төстэй байдал, хүмүүсийн оюун санаанд нөлөөлж буй эрдэм чадлын адил увидас, зэрэг зиндаа, монгол генийн нэг иш үндэс нь чинад оршихуйн учир шалтгаан байж болох юм. Онцгой содон үзэгдэл юмс, тайлагдаагүй нууцыг сонирхон судлаачид хийгээд өргөн олон уншигчдад зориулав.

86.4

М 816

ЭШФ Т-23825

ГҮН УХААН

Гомбосүрэн Ц. **Философи**: Сурах бичиг / Ред. М.Отгонбаяр.- 5 дахь хэвл.- УБ.: Артсофт, 2020.- 560х.



Эл бүтээлд философийн мэдлэгийн үүсэл, үндсэн асуудал, судлах зүйл, философийн түүхэн ба орчин үеийн сургаалууд, эртний дорно дахины ба Энэтхэг, Хятад, Грек, Ромын философи, монголчуудын гүн ухааны сэтгэлгээний түүх, дундад зууны Еврпын философийн түүх, тэдгээрийн урсгал чиглэл, үзэл номлол, хэл шинжлэлийн (лингвистик) философи, материаллаг ахуй ба байгаль ба нийгэм, шашин, хүн ба сэтгэл ухамсар, мэдлэг танин мэдэхүй, логик, соёл, ёс зүй болон нийгмийн өргөн хүрээний салбарын гүн ухааны

судлагдахууныг бүхэлд хамруулан тайлбарласан байна. Тав дахь удаагаа шинэчлэгдэн хэвлэгдэж буй энэ сурах бичгийг их, дээд сургуулийн оюутан, багш, судлаач, нийт уншигчдад зориулжээ.

87.3я73

Г 531

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23700-23702

Соёлмаа С. **Философийн үндсэн мэдэгдэхүүн** / Ред. Г.Чулуунбаатар; Техник ред. Б.Болор-Эрдэнэ; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Ч.Амарзаяа.- УБ.: Соёмбо принтинг, 2020-192х.- ISBN 978-9919-23-652-6.

Тус гарын авлагад эртний ба дундад зууны, сэргэн мандалтын ба шинэ үеийн сонгодог философи, орчин үеийн философийн үүсэл хөгжил, урсгал чиглэлүүд, судлагдахуун болон Монголчуудын гүн ухааны сэтгэлгээний түүхэн тоймыг хамруулан багтаасан байна. Уг ном нь философи, сэтгэлгээний түүх соёл, хүний хөгжил зэрэг хичээлийг сонгон судалж буй их дээд сургуулийн оюутнууд, багш, судлаач, философийг сонирхон судалж буй хэн бүхэнд зориулав.



87.3

С 525

/НХУУТ-4/

ЭШФ Б-29822-29824

Дарьхүү Р. ба бус. **Ёс суртахууны боловсрол** / М.Золзаяа, Д.Оюунгэрэл.- УБ.: Тотопресс, 2020.- 180х.- ISBN 978-9919-23-152-1.

“Ёс суртахууны боловсрол” гарын авлага нь ерөнхий боловсролын сургуулийн “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийн гол хэрэглэгдэхүүн болохоос гадна бүх нийтийн ёс суртахууны боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

Гарын авлагад “Хүний хөгжил ба ёс суртахууны боловсрол”, “Ёс зүй ба ёс суртахуун”, “Ёс суртахууны хэм хэмжээ”, “Ёс суртахууны үндсэн зарчим”, “Төв үзэл: шүтэн барилдахуйн ухаан”, “Ёс суртахууны ойлголтууд”, “Ёс суртахууны үнэлэмж”, “Өөрийгөө танин мэдэхүй”, “Хэрэглээний ёс зүй”, “Ёс суртахууны эрхэмлэл”, “Гэр бүлийн ёс зүй”, “Харилцааны ёс зүй”, “Мэргэжлийн ёс зүй” зэрэг сэдвүүд багтжээ.

87.7

Д 384

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б-29787-29789

Добэлли Р. **Сайхан амьдрах урлаг = Die kunst des guten lebens**: Аз жаргал, эд баялаг, амжилтад хүргэх 52 зөвлөмж = 52 überraschende wege zum gluck / Орч. Т.Ариунсанаа; Техник ред. Б.Болдбаатар, В. Уянга; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Нэпко, 2019.- 253х.- ISBN: 978-9919-500-24-5.



Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа хойш сайхан амьдралыг хүсэж мөрөөдсөөр ирсэн. Сайхан амьдрахын тулд юу хэрэгтэй вэ? Хувь тавилан үүнд хамаатай юу? Мөнгө үүнд хэрэгтэй юу? Сайхан амьдрал сэтгэлгээтэй холбоотой зүйл үү, аль эсвэл амьдралдаа ямар нэг бодит, тодорхой зорилгод хүрнэ гэсэн үг үү? Хүн аз жаргалын хойноос зориудаар хөөцөлдөх ёстой юу аль эсвэл зүгээр л таагүй байдлаас зугтаахад л болоод явчих уу? гэх мэт сонирхолтой агуулгын хүрээнд ойлгомжтой тайлбарлажээ.

87.7

Д 428

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б-29796-29798

Дулам С. **Монгол бэлгэдэл зүй**: 4 боть / Ред. Д.Бум-Очир; Диз. Г.Самдан.- 5 дахь хэвл.- УБ.: Битпресс, 2020.- 284х.- (МУИС-Утга зохиол, урлаг судлалын тэнхим).- ISBN 99929-5-052-8.

87.774(1)

Д 642

Б.1: Тооны бэлгэдэл зүй.- 284х.- (Монгол соёлын чуулган VIII)

Судлаач тус бүтээлдээ эрт цагаас монголчуудын уламжлалт соёл сэтгэлгээнд тоо болгон бэлгэдлийн давтагдашгүй бодгаль бэлгэ чанартай байсан гэдгийг бэлгэдэл зүйн ухааны үүднээс судлан тайлбарласан. Тэрээр монгол ардын аман зохиол, уран зохиолын сонгодог эх сурвалжуудад түгээмэл тохиолддог монголчуудын ахуй амьдрал, зан заншил, газар усны нэр, үлгэр домгийн үг хэллэгийн утга санаа, давтамжийн илэрхийлэлийг шинжлэн судалж, тооны бэлгэдэл чанарын утгыг тайлж, гаргалгаа хийсэн байна.

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23604-23606



Б.2: Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй.- 320х.- (Монгол соёлын чуулган IX)

Монголчуудын өнгөөр бэлгэдэх ёсны утга зүйг ухан шинжиж, судлан тайлбарласан энэхүү бүтээлд байгалийн юмс үзэгдлийн өнгийг тэмдэглэхээс эхлээд тэдгээрийн бүтвэр махбодын өнгийг нэрлэх, орон зай, зүг чигийг заах (сансрын бэлгэдэл), язгуур давхарга, үндэстэн угсаатныг ялгах, ёс зүйн болон хийсвэр ойлголтыг бэлгэдэх мэтчилэнгээр хэд дахин салбарлаж, нарийвчлан гүнзгийрүүлэн авч үзсэн байна. Тухайлбал монголчууд тэнгэрийг өнгөөр төлөөлүүлж "хөхрөгч", "хөхөлзөгч" гэж нэрлэдэг байхад ногоог ногоон өнгөтэй нь, шороог шар өнгөтэй нь тус тус адилтган нэрлэдэгийг дурджээ. Түүнчлэн тус номын "Зүг чигийн бэлгэдэл зүй" хэсэгт орон зайн тухай шинжлэх ухааны үзэл ойлголтод үл хамаарах, уран сайхны, домог туурвилын, шүтлэг мөргөлийн юмуу бэлгэдлийн орон зай, түүний нийтэд илэрхий хэд хэдэн хэмжээсийн талаар өгүүлжээ.

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23607-23609



Б.3: Дүрсийн бэлгэдэл зүй, дохио зангааны бэлгэдэл зүй.- 208х.- (Монгол соёлын чуулган X).

Энэхүү бүтээлд дүрсийн тэмдэг бэлгэдлийн гайхамшигт жишээ болох монгол мал, амьтны им тамгадын үндсэн болон хувилбар дүрсүүд, хадны сүг зурагт цавчигдан үлдсэн мөр улбаанаас нь үндэслээд тэдний эртний угшилтай болох хийгээд овог аймгийн ялгац тэмдэг болох учир шалтгааны талаар судлаач мэргэдийн онож тогтоосон судалгаа шинжилгээг багтаажээ.

Уг судалгааны ажлын зорилго нь эдгээр дүрсийн уг тэмдэглэгдэхүүн нь юу болох хийгээд түүний хувилбарууд нь юуг илэрхийлэх, бэлгэдлийн утга учир нь юу болохыг тогтооход оршино.

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23610-23612



Б.4: Зүүд, зөн совингийн бэлгэдэл зүй, цагийн бэлгэдэл зүй.- 220х.- (Монгол соёлын чуулган XI).

Хүн төрөлхтний соёл иргэншлийн алс эрт үед хүн зүүднийхээ учир утгыг тайлахыг оролдон зүүдээр уламжлан ирээдүйг мэдэх зүүд тайлал (oneiromancie, ониромантия) хэмээх эрдэм ухааныг ч бүтээсэн байдаг.

Энэхүү судалгааны бүтээлд зүүд гэж юу болох, зүүдний талаарх монголчуудын үзэл, зүүдний тайлал, бэлгэдэл, зөн совингийн бэлгэдэл, хүн ба амьтны зөн совинг авч үзжээ. Номын дараагийн хэсэгт цагийн бэлгэдэл ба өдөр, шөнө, сар улирал, жилийн цаг хугацааны бэлгэдэлт нэршил тэдгээрийн ёслол ба цээрлэлийн талаар монголчуудын уламжлалт ахуй соёлтой холбон тайлбарласан байна.

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23613-23615



Монгол мэргэдийн мянган цэцлэл / Эмхт. А.Пүрэвжанцан, Ж.Нарангэрэл; Эх бэлт. М.Ууганцэцэг.- УБ.: Алмаз пресс, 2020.- 138х.- ISBN 978-9919-23-670-0.

Уг бүтээлд зөвхөн Монгол газар шороон дээр, Монгол хүний оюун билгээр цэцэлсэн, Монгол ахуй соёлыг илэрхийлсэн, Монголоос өөр хэн ч ингэж хэлж чадашгүй гайхалтай мэргэн үгс, эшлэл санаа, мөр шүлгийг түүж эмхэтгэхийг зорьсон болно. Мөн олон хүмүүсийн энэ мэтээр бичсэнийг давтахгүйг хичээж, цаг хугацааны хувьд тун ихэнх нь ойрмогхоны, нас намбын хувьд зургаан настай балчраас эхлээд зуугаад настай буурал хүртэл, эрдэм чадлын хувьд энгийнээс энгүй хүмүүсийн айлдсан, утга чинадын хувьд гүн гүнзгий, бат нот үгсийг эшилсэн гэж ойлгож болно.

87.774(1)

М 692

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29805-29807



Мэнсон М. **Бүх зүйл новш = Everything is f*cked:** Итгэл найдварын тухай ном = A book about hope / Англи хэлнээс орч. Б.Байгалмаа; Орч. ред. Г.Сугиррагчаа; Ред. Ж.Хишигжаргал, П.Сарангарав, С.Батжаргал; Эхийг бэлт. С.Батжаргал.- УБ.: Монсудар, 2019.- 330х.- ISBN 978-99973-1-781-0.



Зохиолч энэхүү бүтээлдээ итгэл найдвар гэгч хичнээн чухал болох талаар өгүүлжээ. Тэрээр “Бидний оюун ухааны хөдөлгүүрийн түлш нь итгэл найдвар юм” гэж тодорхойлсон байна. Харамсалтай нь, бид өмнөх үеийнхнийхээ төсөөлж ч чадахааргүй материаллаг элбэг хангалуун байдал, техник технологийн дэвшлийг хүртэж байгаа ч дэлхийн түүхэнд урьд хожид байгаагүй итгэл найдвараа алдсан хүмүүс болжээ. Учир нь дэлхий ертөнц сайхан болох тусам бид илүү ихийг алдах ёстой болно. Ихийг алдах тусмаа бидний итгэл найдвар буурна. Энэ бол хөгжил, дэвшлийн парадокс. Энэ зүйл биднийг хэрхэн улам бүр итгэл найдвараа алдаж, горьдлого тасарсан ганцаардмал амьтан болгон хувиргаж байгааг харуулахын тулд тэрээр шинжлэх ухааны судалгааг өөрийн хэв маягийн хошигнолтой хослуулан бичжээ.

87.7

М 263

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б-29830-29832

СЭТГЭЛ СУДЛАЛ

Гётц Т. **Сэтгэлийн хөдөлгөөн, сэдэлжилт болон өөрийн удирдлага зохицуулалттай суралцах** / Орч. Б.Туяа; Орчуулгын ред. Г.Ариунцэцэг; Ред. Ж.Амар; Ерөн. ред. Б.Дэлгэрмаа; Техник ред. Ж.Хишигжаргал; Диз. С.Батжаргал.- УБ.: Монсудар, 2018.- 228х.- ISBN 978-99973-1-448-2.



Хүний сэтгэлийн хөдөлгөөн гэж юу болох, сэтгэлзүйд ямар процесс явагддаг талаас нь тайлбарлаж, мөн багшийн зүгээс сурагчдад суралцах үйлд сэтгэлийн хөдөлгөөнөө зөв удирдаж сурахад тусалж дэмжих, чиглүүлэх үүрэгтэйг онцолжээ. Мөн багш сэтгэлийн хөдөлгөөний эрүүл мэндээ хамгаалах хэрэгтэйг зөвлөхийн сацуу сэтгэл зүйн өдөөлт буюу сэдэлжилт гэж юуг хэлэх вэ?, сэдэлжүүлэлтийн хэрэгцээ, үр дагавар, сэтгэлийн хөдөлгөөн, сэдэлжилт, өөрийн удирдлага зохицуулалтын талаар тайлбарласан байна. Энэхүү номыг багш болохоор сурч буй оюутнууд, багшийн мэргэжлээ дээшлүүлж буй, багшаар ажиллаж буй хүн бүрт зориулжээ.

88.8

Г 34

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Б-29811-29813

Мөнхцэцэг Д. **Хүний хөгжил ба сэтгэл зүйн зөвлөгөө** / Ред. Ш.Эрдэнэчимэг, Б.Отгонжаргал.- 2 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 256х.- ISBN 978-9919-22-839-2.



Хүний хөгжлийг сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс энгийн үг хэллэгээр тайлбарласан энэхүү бүтээл нь бие биенээсээ харилцан

хамааралтай байдаг сэтгэл судлалын судлагдахууныг хүний хөгжил, хүүхдийн хөгжил, сэтгэцийн эрүүл мэнд гэсэн 3 бүлэгт хуваан, монгол хүний сэтгэл зүйн онцлог, зан төлөвийг судлан тайлбарлажээ.

Өөрийгөө таньж мэдэхийг хүсэж буй эгэл нэгнээс эхлэн байгууллагын удирдах ажилтан, хүний нөөцийн мэргэжилтэн, хүний хөгжлийн зөвлөхүүд, оюутан, багш, судлаач, нийгмийн ажилтан нарт зориулав.

88.52

М 816

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Б-29842-29844

Оюун Ж. **Амжилттай аз жаргалтай эмэгтэйн хөтөч:** Өдөр бүрийн жижиг алхмаар өөрийн түлхүүрээ олон санхүүгийн асуудлаа шийдэн зорилгоо биелүүлэх 30 хоногийн коучинг / Хян. Х.Айгул; Диз. Д.Оюун.- УБ.: Адмон принт, 2019.- 188х.- ISBN 978-9919-22-442-4.

Амьдралын нугачаанд сөгдчихгүй, сөхөрсөн ч босох хүчтэй, үр хүүхдүүдээ аз жаргалтай, өөртөө итгэлтэй, сэтгэл хангалуун, сайн хүмүүс болгож өсгөх, хийхийг хүссэн зүйлээ санхүүд баригдалгүйгээр дураараа хийх, хүмүүст чадах чинээгээрээ тусалдаг, амжилттай төдийгүй аз жаргалтай эмэгтэй байхад тань туслах 30 хоногийн коучинг тус бүтээлд багтсан байна. Таны өөрөө ч мэдэхгүй байгаа, дотор нь хэзээ гялалзахаа хүлээн нуугдаж байгаа үнэт эрдэнэс мэт чадвар, нөөц бололцоог нь өөрт нь харуулж, саад тотгорыг сайхан боломж болгон хувиргаж, асуудлыг ч аз жаргалд урвуулах ухаанаа олж харахад тань энэхүү ном тусална.

88.52

О-634

/НХУУТ-3/

ЭШФ Б-29845-29846

Эрдэнэчулуун Д. **Мэргэжил сонголтын сэтгэл зүйн үндэс:** Сэтгэл судлаач, багш, нийгмийн ажилтан, ахлах ангийн сурагчид, хөдөлмөрийн бирж болон зөвлөх үйлчилгээний мэргэжилтнүүдэд зориулсан ном / Хян. Э.Нарантунгалаг; Эмхт. Д.Эрдэнэчулуун; Эх бэлт. П.Номинцэцэг; Хавтасны диз. Э.Доржханд.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 116х.- ISBN 978-9919-22-818-7.



Энэхүү номонд олон арван мэргэжлийн диплом өвөрлөсөн залуус ажилгүйчүүдийн эгнээг өргөжүүлж, нийгмийн амьдралын ядуурал доройтлыг нэмэгдүүлж байгаа үйл явц нь мэргэжил сонголт алдаатай, бодлогогүй, удирдлагагүй, урсгалаараа явагдаж байгааг дурдаад ирээдүйн залуус хэрхэн энэ алдааг давтахгүй байж болох талаар зөвлөжээ. Уг бүтээл нь мэргэжил сонголтод шинжлэх ухааны үндэстэй хандсанаар хожим гарч болзошгүй сэтгэл зүйн хямрал, эдийн засгийн гарз хохирлоос сэргийлж чадах талаар танд хэрэгтэй зөвлөгөөг өгөх болно.

88.37

Э 739

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23638-23640

Баасандорж Э. **Бие хүний сэтгэл судлал:** Орчин үеийн онол болон оношилгоо, сэтгэц заслын аргууд / Хян. Д.Цогзолмаа; Хэвлэлд бэлт. С.Мөнхмаа.- УБ.: Артсофт, 2020.- 177х.- (IAP-Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн).- ISBN 978-99192-3-597-0.



Өнөө үед бие хүний сэтгэл судлал тэр дундаа энэ салбарын практик хэрэглээнд тэргүүлэх үүрэгтэй оролцож буй онол үзэл баримтлалууд, сэтгэц оношилгоо ба сэтгэл заслын аргуудын талаар танилцуулсан гурван бүлэг бүхий ном. Уг номын эхний бүлэгт дээрх үзэл баримтлалууд буюу интерперсонал онол, танин мэдэхүйн онол, хувьслын тухай ухагдахуунд тулгуурласан онол зэрэгт бие хүний онцлогийн тухай хэрхэн тодорхойлсныг голчлон оруулаад дараагийн бүлэгт MMPI-2-RF, MCMI-IV, PAI гэх мэт томоохон асуулгын аргуудын үүсэл хөгжлийн түүх, илрүүлдэг үзүүлэлтүүд зэргийн талаар нэлээд товч тодорхойлолтыг багтаасан. Сүүлийн хэсэг нь Харилцааны Хэв Загварыг Шинэчлэх Засал (IRT), Схемийн засал (ST), Диалектик Зан Үйлийн Засал (DBT), EMDR гэх мэт заслын аргуудын онолын үндэслэл, хэрэглэгддэг техникүүдийн талаар зөвлөгөө мэдээлэл багтжээ.

88.37

Б 109

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23697-23699

Эрдэнэчулуун Д. **Сэтгэл зүйн зөвлөгөөний арга техник:** Сэтгэл зүйч бэлтгэдэг их дээд сургуулийн оюутнууд, сэтгэл судлаач, багш сурган хүмүүжүүлэгчид, гэр бүлтэй ажилладаг мэргэжилтэн, нийгмийн ажилтнуудад зориулсан ном / Хян. Э.Нарантунгалаг; Эх бэлт. Б.Гантулга.- УБ.: Ган принт, 2019.- 142х.- (Монгол Улсын Боловсролын Их Сургууль. Сэтгэл судлалын тэнхим).- ISBN 99929-62-73-9.



Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх анхан шатны арга техникүүд, хувь хүний сэтгэл зүйн асуудлыг шийдвэрлэхэд ашиглаж болох онолын загварууд, мэргэжлийн ур чадвараа сайжруулах дадлага ажлуудыг энэхүү гарын авлагад сонгон оруулсан болно. Сэтгэл судлалын шинжлэх ухааны хэрэглээний салбарын дотор сэтгэл зүйн зөвлөгөө чухал байр суурь эзэлдэг. "Сэтгэл зүйн зөвлөгөө" хэмээх ухаан нь манай улсын хувьд хөгжлийнхөө гарааны шатанд яваа, практик амьдралд нэвтэрч эхэлж байгаа харьцангуй шинэ салбар юм.

88.4в7

Э 739

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23635-23637

Эрдэнэчулуун Д. **Гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө:** Сэтгэл зүйч бэлтгэдэг их дээд сургуулийн оюутнууд, сэтгэл судлаач, сурган хүмүүжүүлэгчид, гэр бүл судлаач, нийгмийн ажилтнуудад зориулсан ном / Эх бэлт. Б.Гантулга.- УБ.: Ган принт, 2019.- 144х.- (МУБИС, Сэтгэл судлалын тэнхим).- ISBN 99929-62-88-4.

Гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө нь сэтгэл судлалын хэрэглээний салбарын дотор чухал байр суурь эзэлдэг биеэ даасан шинжлэх ухаан юм. Энэ бүтээлд гэр бүлд тохиолддог нийтлэг асуудлуудыг шийдвэрлэхэд ашиглаж байгаа сэтгэл зүйн зөвлөгөөний онол-арга зүйн асуудлуудыг онцлон авч үзжээ. Ялангуяа эцэг эхчүүд өөрсдөө энэ номд оруулсан практик зөвлөмж, арга техникүүдийг гэр бүлийн асуудлаа шийдвэрлэхэд хэрэглэн турших боломжтой юм. Мөн өдөр тутмын амьдралын тохиолдол, жишээнүүд, асуулт даалгавар, зөвлөмжүүдийг оруулж өгсөн нь тухайн салбарын оюутан суралцагсдад "Сэтгэл зүйн зөвлөгөө, алба" хичээлээр олж авсан онолын мэдлэгээ гүнзгийрүүлэн бататгахад ач холбогдолтой болно.



88.5

Э 739

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23694-23696

НОМ ЗҮЙН ЛАВЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА

Монгол улсын Үндэсний номын сан дахь архивын бүртгэн мэдээлэх ном зүй: Б.7: 2010-2019 он / Ерөн. ред. Д.Энхтунгалаг; Эмхт. Д.Энхтунгалаг, Х.Ундрах.- УБ.: Соёмбо принтинг, 2019. - 556х.- (Монгол Улсын Үндэсний Номын Сан).- ISBN 978-9919-9567-4-5.



МУ-ын Үндэсний номын сан нь 1921 оноос өнөөг хүртэл монгол улсад хэвлэгдсэн ном бүрээс авч архивлан хадгалж ирсэн бөгөөд тус архив фондоод хадгалагдаж буй 1921-2010 онд хэвлэгдсэн номуудын ном зүйн мэдээлэлийг агуулсан 5 боть бүртгэлийг эмхэтгэн олны хүртээл болгосон билээ. Түүний үргэлжлэл болох энэхүү 7-р ботид 2010-2019 онд тус фондоод шинээр нэмэгдсэн номуудын ном зүйн мэдээллийг хамруулсан бөгөөд дотор нь нэрийн үсгийн дарааллаар байрлуулж, төгсгөлд нь хүний нэрийн хэлхээсийг хийж өгсөн байна. Уг ном зүйн бүртгэл нь эрдэмтэн судлаачид, номын сангийн ажилтнууд, нийт уншигчдад зориулагдсан болно.

91

М 692

/НХУУТ-2, Лав-1/

ЭШФ Т-23534-23535


АНГЛИ ХЭЛ ДЭЭРХИ НОМНУУД

Iserles A. **A first course in the Numerical analysis of differential equations.**- 2nd ed.- Cambridge University Press, 2009.- 459p.- (Cambridge texts in applied mathematics).- ISBN 978-0-521-73490-5.

This second edition has been extensively updated, and includes new chapters on emerging subject areas: geometric numerical integration, spectral methods and conjugate gradients. Other topics covered include multistep and Runge-Kutta methods; finite difference and finite elements techniques for the Poisson equation; and a variety of algorithms to solve large, sparse algebraic systems.

22.161

I 85




ГФ-20118

Carroll B.W., Ostlie D.A. **An introduction to modern astrophysics.**- 2nd ed.- NY.: Cambridge University press, 2017.- 1278p.- ISBN 978-1-108-42216-1.

An Introduction to Modern Astrophysics is a comprehensive, well-organized and engaging text covering every major area of modern astrophysics, from the solar system and stellar astronomy to galactic and extragalactic astrophysics, and cosmology. Designed to provide students with a working knowledge of modern astrophysics, this textbook is suitable for astronomy and physics majors who have had a first-year introductory physics course with calculus.

22.632

C 21




ГФ-20119

Atkins P. and other. **Atkins' Physical Chemistry** / Paula J.De. Keeler J.- 11th ed.- NY.: Oxford University Press, 2018.- 908p.- ISBN 978-0-19-876986-6.

Atkins' Physical Chemistry is widely acknowledged by both students and instructors around the globe to be the textbook of choice for studying physical chemistry. The eleventh edition has been enhanced with additional learning features and math support, and reorganized into discrete Topics, to make the text more flexible for teachers and more readable for students. Web Assign. New for this edition, Atkins' Physical Chemistry can be packaged with Web Assign, a flexible and fully customizable online instructional solution. It allows instructors to deploy assignments and to instantly assess individual student performance. For packaging information, or to arrange a demo, contact your OUP sales representative.

24.5

A 90



ГФ-20121

Smith Thomas M., Smith Robert L. **Elements of ecology.**- 8th ed.- NY.: Pearson education limited, 2015.- 704p.- ISBN 978-1-292-07740-9.

Elements of Ecology, Ninth Edition continues to explain ecological processes clearly and concisely, with a greater emphasis on the relevance of ecology to everyday life and the human impact on ecosystems. This dramatically revised edition discusses issues of human ecology throughout the text and provides a greater variety of opportunities for students to learn, practice, and develop quantitative and analytical skills. Current research examples and other content updates are supported by more than 200 redesigned, full-color illustrations, graphs, and tables.

28.09

S 68




ΓΦ-20120

Albaum G. and other. **International marketing and export management** / E.Duerr, A.Josiassen.- 8th ed.- Harlow.: Pearson, 2016.- 715p.- ISBN 978-1-292-01692-4.

The book covers the evolving internationally competitive landscape that almost all firms and consumers find themselves acting in today. Consumers because they often make consumption choices where there are international options, and firms because they either compete internationally or have international competitors in their domestic market.

65.290-2

A 30




ΓΦ-20115

Weygandt J.J. and other. **Accounting principles** / P.D.Kimmel, D.E.Kieso; Ed by. Michael McDonald.- 12th ed.- Hoboken.: Wiley, 2015.- 1189p.- (Weygandt kimmel kieso team for success).- ISBN 978-1-118-87505-6.

Accounting Principles 12th Edition by Weygandt, Kimmel, and Kieso provides students with a clear introduction to fundamental accounting concepts. The Twelfth Edition helps student get the most out of their accounting course by making practice simple. This text allows for new opportunities for self-guided practice allow students to check their knowledge of accounting concepts, skills, and problem-solving techniques and receive personalized feedback at the question, learning objective, and course level.

65.052


W 37



ΓΦ-20122

Rainey, Hal G. **Understanding and managing public organizations.**- 5th ed.- San Francisco.: Jossey-Bass, 2014.- 571p.- ISBN 978-1-118-58371-5.

Machine generated contents note: Figures, Tables, and Exhibits Preface The Author Part One The Dynamic Context of Public Organizations 1 The Challenge of Effective Public Organization and Management 2 Understanding the Study of Organizations: A Historical Review 3 What Makes Public Organizations Distinctive 4 Analyzing the Environment of Public Organizations 5 The Impact of Political Power and Public Policy Part Two Key Dimensions of Organizing and Managing 6 Organizational Goals and Effectiveness 7 Formulating and Achieving Purpose: Power, Decision Making, and Strategy 8 Organizational Structure, Design, Technology, Information Technology, and Social Media 9 Understanding People in Public Organizations: Motivation and Motivation Theory 10 Understanding People in Public Organizations: Values, Incentives, and Work-Related Attitudes 11 Leadership, Managerial Roles, and Organizational Culture 12 Teamwork: Understanding Communication and Conflict in Groups Part Three Strategies for Managing and Improving Public Organizations 13 Managing Organizational Change and Development 14 Advancing Effective Management in the Public Sector References Additional Reference Materials Name Index Subject Index .



66

R 17

/OYXHYC-1/

ГФ-20116

Luvsandendev S. and other. **Voters Voices:** Based on people's perception of Mongolia's political, economic and social developments as reflected in opinion polls in 2008-2016: Volume-2 / W.Prohl, S.Tsogt-Ochir.- UB., 2018.- 659p.- ISBN 978-99978-2-588-9.



This second volume adds research result from nearly 20,000 interviews conducted in the years 2008 to 2016 from the Sant Maral Foundation database. The book details Mongolia's political, economic, and social developments, as well as the political system of other countries, as well as major countries such as Russia, China, USA, Japan, and South Korea.


66.3(1)

S 91

/OYXHYC-5/

ГФ-20123-2012

Gaddis J.L.**On grand strategy.**- NY.: Penguin press, 2018.- 368p.- ISBN 978-1-59420-351-0.



“On Grand Strategy,” by John Lewis Gaddis, a pre-eminent historian and biographer of the Cold War, does not offer a comprehensive analysis, much less a history, of strategy on a grand scale in the manner of the classic studies by Angelo Codevilla, Edward Mead Earle, Lawrence Freedman, B. H. Liddell Hart, Edward N. Luttwak or Williamson Murray. Gaddis does concede that “grand strategies have traditionally been associated, however, with the planning and fighting of wars.” And so wars — or rather how not to lose them — are the general theme of his often didactic book.

68.4

G 12

ГФ-20117

National museum of Mongolia: General catalogue / Edit. D.Sukhbaatar, J.Bayarsaikhan, Ts.Odbaatar; Advisors. J.Boldbaatar, Z.Lonjid, Ts.Turbat, U.Erdenebat; Trans. B.Boldbaatar; Des. Ts.Gansuld, S.Narantuya; Photographer M.Bars, V.Battulga, Ch.Bayandelger.- UB.: Munkhiin useg, 2020.- 359p.- ISBN 978-99978-748-6-3.



The Mongolian National Museum has a rich collection of ancient historical artifacts within the hall. In this book including Ancient Mongolian history; history of ancient countries; Mongolian traditional clothes and jewelry; Mongolian empire (XIII-XIV centuries); Traditional culture; traditional economy; Socialist period (1921-1989); Democratic Mongolia; 1990 to since; the within the hall are described with a detailed description.

79.1(1)

M 97

ГФ-20126